



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



Spread the skills, fill the gaps
GENEPRO

“ЕРӨНХИЙ МЭРГЭШИЛ СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТАНД ЗОРИУЛСАН ГАРДАН ҮЙЛДЛИЙН ГАРЫН АВЛАГА



“ЕРӨНХИЙ МЭРГЭШИЛ СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТАНД ЗОРИУЛСАН “ГАРДАН ҮЙЛДЛИЙН ГАРЫН АВЛАГА”

Энэхүү номыг ЖАЙКА-гийн “Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан болно.

Гарын авлага боловсруулсан ажлын хэсэг:

- Б.Батсүх: Орхон аймгийн БОЭТ-ийн захирал, мэс заслын тэргүүлэх зэрэгтэй, эмнэлзүйн сургагч багш, Клиникийн профессор
- Д.Лхагва: Орхон аймгийн БОЭТ-ийн Мэс заслын зөвлөх эмч, МУ-ын гавьяат эмч, эмнэлзүйн сургагч багш, Клиникийн профессор
- Б.Батбаяр: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн зөвлөх эмч, тэргүүлэх зэрэгтэй, чиглүүлэгч багш, Клиникийн профессор
- Ц.Наран-Эрдэнэ: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн эрхлэгч, чиглүүлэгч багш, ахлах зэрэгтэй
- М.Уртнасан: Орхон аймгийн БОЭТ-ийн хүүхдийн зүрх судасны их эмч, хүүхдийн тасгийн эрхлэгч, НЭМ-ийн магистр, чиглүүлэгч багш
- Д.Сүхээ: Орхон аймгийн БОЭТ-ийн Мэс заслын тасгийн эрхлэгч, эмнэлзүйн сургагч багш, АУ-ны магистр, ахлах зэрэгтэй
- Р.Эрдэнэзаяа: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн их эмч, ахлах зэрэгтэй, эмнэлзүйн сургагч багш, Клиникийн профессор, НЭМ-ийн магистр
- Д.Баярхүү: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн их эмч, эмнэлзүйн сургагч багш, ахлах зэрэгтэй
- Б.Барьчидсүрэн: Орхон аймгийн БОЭТ-ийн ЭБЭ-ийн тасгийн их эмч, эмнэлзүйн сургагч багш, ахлах зэрэгтэй, НЭМ-ийн магистр
- Т.Цэцэгдарь: Орхон аймгийн БОЭТ-ийн ЭБЭ-ийн эмч, эмнэлзүйн сургагч багш, ахлах зэрэгтэй, НЭМ-ийн магистр
- Б.Цэндбаяр: Орхон аймгийн Тархвар судлаач, АУ-ны магистр, ахлах зэрэгтэй
- М.Алтанбек: Орхон аймгийн БОЭТ-ийн Гэмтлийн тасгийн их эмч, эмнэлзүйн сургагч багш, НЭМ-ийн магистр
- Л.Төгөлдөр: Орхон аймгийн БОЭТ-ийн Мэс заслын тасгийн их эмч, НЭМ-ийн магистр
- Г.Дэлгэрцогт: Орхон аймгийн БОЭТ-ийн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эмч
- О.Оргилбаатар: Орхон аймгийн БОЭТ-ийн Хүүхдийн Яаралтай тусламжийн их эмч, эмнэлзүйн сургагч багш
- Б.Номин: Орхон аймгийн БОЭТ-ийн Хүүхдийн мэдрэлийн их эмч
- Д.Мишээлтбаяр: Орхон аймгийн БОЭТ-ийн Түргэн тусламжийн тасаг,

Ерөнхий мэргэжлийн эмч

- Б.Эрдэнэцэцэг: Орхон аймгийн БОЭТ-ийн Сувилахуйн албаны дарга, сувилахуйн сургагч багш, тэргүүлэх зэрэгтэй
- Л.Эрдэнэчимэг: Орхон аймгийн БОЭТ-ийн Сувилахуйн албаны арга зүйч, тэргүүлэх зэрэгтэй
- М.Ундрахсайхан: Орхон аймгийн БОЭТ-ийн Гадаад харилцаа, сургалт эрдэм шинжилгээ хариуцсан ажилтан
- Мурохара Хомарэ: Дэлхийн улс орнуудын алслагдсан бүсэд эрүүл мэндийн хүний нөөцийг бэлтгэх хөтөлбөрт (<https://genepro.org>) хамрагдсан эмч

Видео бичлэг боловсруулахад оролцсон:

- Г.Цолмонхүү: Орхон аймгийн ЭМГ-ийн НЭМТ-ийн зураглаач
- Н.Цэнд-Аюуш: Орхон аймгийн ЭМГ-ийн НЭМТ-ийн сэтгүүлч
- Д.Оюунчимэг: Орхон аймгийн БОЭТ-ийн Хүүхдийн тасгийн ахлах сувилагч, сувилахуйн ахлах зэрэгтэй
- Б.Ууган-Эрдэнэ: Орхон аймгийн БОЭТ-ийн Гэмтлийн тасгийн сувилагч
- Ч.Соёлмаа: Орхон аймгийн БОЭТ-ийн Гэмтлийн сувилагч
- М.Даваасүрэн: Орхон аймгийн БОЭТ-ийн Мэдрэлийн тасгийн сувилагч
- Б.Анхцэцэг: Орхон аймгийн БОЭТ-ийн Мэдрэлийн тасгийн сувилагч
- М.Мөнхзаяа: Орхон аймгийн БОЭТ-ийн Үйл оношийн тасгийн лаборант
- П.Өлзий-Орших: Орхон аймгийн БОЭТ-ийн Нярайн тасгийн сувилагч
- Г.Туяачимэг: Орхон аймгийн БОЭТ-ийн Нярайн тасгийн сувилагч
- Г.Нарангэрэл: Орхон аймгийн БОЭТ-ийн Халдвартын тасгийн ахлах сувилагч, тэргүүлэх зэрэгтэй
- Х.Даваасүрэн: Орхон аймгийн БОЭТ-ийн Халдвартын тасгийн сувилагч, ахлах зэрэгтэй
- Ж.Мядагмаа: Орхон аймгийн БОЭТ-ийн Дотрын тасгийн сувилагч
- Л.Оюунсүрэн: Орхон аймгийн БОЭТ-ийн Дотрын тасгийн сувилагч
- Х.Түмэнцэцэг: Орхон аймгийн БОЭТ-ийн Төрөх тасгийн эх баригч
- Д.Хулан: Орхон аймгийн БОЭТ-ийн Төрөх тасгийн эх баригч
- Д.Даариймаа: Орхон аймгийн БОЭТ-ийн Төрөх тасгийн эх баригч
- Р.Эрдэнэсүвдаа: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн ахлах сувилагч, сувилахуйн тэргүүлэх зэрэгтэй
- М.Нямсүрэн: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч, тэргүүлэх зэрэгтэй
- Ж.Уранцэцэг: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч,

ахлах зэрэгтэй

- Б.Нарандулам: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч, ахлах зэрэгтэй
- Б.Туул: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- С.Оюунчимэг: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- С.Хоролсүрэн: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- Б.Дэлгэрсүрэн: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- Г.Сэрсэндэмид: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- Б.Пүрэв-Очир: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- Ч.Энх-Амгалан: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- М.Номинчимэг: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- Х.Саранзаяа: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- Б.Алтан-Эрдэнэ: Орхон аймгийн БОЭТ-ийн ЯТЭЭМТ-ийн тасгийн сувилагч
- Ё.Амарцэцэг: Орхон аймгийн БОЭТ-ийн Мэс заслын тасгийн ахлах сувилагч
- Э.Мөнхцацрал: Орхон аймгийн БОЭТ-ийн Мэс заслын тасгийн сувилагч
- Л.Хишигдаваа: Орхон аймгийн БОЭТ-ийн Мэс заслын тасгийн сувилагч сувилахуйн ахлах зэрэгтэй

Хянасан:

С.Алтансүх: Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэгийн тэргүүн, УНТЭ-ийн яаралтай тусламжийн төвийн дарга

Д.Мягмарцэрэн: ЭМЯ-ны Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, АШУҮИС-ийн Өрхийн тэнхмийн эрхлэгч, АУ-ны доктор, дэд профессор

Д.Мөнхцэцэг: ЭМЯ-ны Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, АШУҮИС-ийн Эх барих, эмэгтэйчүүд судлалын тэнхмийн эрхлэгч, АУ-ны доктор

Г.Ганхуяг: АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Суурь сувилахуйн тэнхмийн ахлах багш, БСУ-ны доктор, тэргүүлэх зэрэгтэй

Дэмжин ажилласан:

Д.Баярмаа: ЭМЯ-ны Төрийн Захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн, Анагаах ухааны магистр

Н.Сэвжид: ЭМХТ-ийн ХНБЗА-ны дарга, Анагаах ухааны магистр

П.Эрхэмбаяр: ЭМХТ-ийн ХНБЗА-ны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр

Д.Баярхүү: ЭМХТ-ийн ХНБЗА-ны мэргэжилтэн

АГУУЛГА

Өмнөтгөл	6
Гар угаах, халдваргүйжүүлэх заавар	7
Гар угаах арга:.....	15
Эмнэлгийн хувцас өмсөх арга	19
Онцгой нөхцөлд хамгаалах хувцас, хэрэгсэл өмсөх арга:	24
Амьсгалын зам чөлөөлөх энгийн арга.....	29
Цэр салстыг соруулах.....	35
Зүрхний цахилгаан бичлэг хийх арга.....	37
Ходоодонд хаймсuur тавих арга	42
Судасны хүрц буюу уян зүү тавих арга	46
Ясанд шингэн сэлбэх хүрц хийх арга техник	52
Судсанд тарилга хийх арга	56
Булчинд тарилга хийх арга.....	62
Арьсан дор тарилга хийх арга.....	68
Оёдол тавих, цус тогтоох, шарх цэгцлэх арга.....	74
Цус тогтоох чангалуур тавих арга.....	81
Шинжилгээнд цус авах арга	85
Цусанд глюкозын хэмжээг тодорхойлох арга	89
Давсганд гуурс байрлуулах арга.....	92
Эх барихын гардан үйлдэл: Гадуур үзлэг.....	100
Эх барихын гардан үйлдэл:Умайн ёроолын өндөр үзэх	103
Эбэ-ийн гардан үйлдэл: Үтрээний үзлэг.....	106
Эбэ-ийн гардан үйлдэл: Аарцаг хэмжих.....	108
Умайн хүзүүний эсийн шинжилгээ авах арга	111
Ашигласан материал:	115

QR кодыг уншуулахад *android, iphone, ipad, tablet* зэрэг төхөөрөмжүүдэд **QR Scanner** программ татаж суулгаж уншуулна. Ингэснээр тухайн QR кодны холбоосонд байгаа дүрс бичлэг таны гар утас болон таблет төхөөрөмжинд нээгдэх болно.

Үе хэдий бага ч хэрүүлийн шалтаг
Өвчин хэдий бага ч үхлийн шалтаг
Өө хэдий бага ч гажихын шалтаг

ӨМНӨТГӨЛ

Монгол улс, Япон улсын засгийн газрын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн дагуу ЭМЯ, ЭМХТ, Япон улсын хамтын ажиллагааны Жайка байгууллагаас “Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийг Орхон аймгийн БОЭТ-тэй хамтран амжилттай хэрэгжүүлж байгаа билээ.

Энэ төслийн хүрээнд Япон улсад бэлтгэгдсэн эмнэлзүйн чиглүүлэгч болон сургагч багш нар, БОЭТ-ийн эмч болон сувилагч нартай хамтран эмнэлгийн тусламж үйлчилгээний салшгүй чухал бүрэлдэхүүн болох гардан үйлдлүүдийн тухай гарын авлагыг сургалтын дүрс бичлэгийн хамт бүтээж, хэвлүүлж байгаад талархаж байна.

Ерөнхий мэргэшил судлалын резидент эмч нарт зориулсан “Гардан үйлдлийн гарын авлага” ном болон сургалтын дүрс бичлэг нь Монгол улс болон олон улсын стандартад нийцсэн, эмнэлгийн мэргэжилтэнүүдийн сургалтанд ашиглахад хялбар, ойлгомжтой, аливаа гардан үйлдлийн ажилбарт хандах зөв хандлага, чадварыг хэвшүүлэх, эмчлүүлэгчид үзүүлэх тусламж, үйлчилгээ нь ямагт аюулгүй, үр дүнтэй, шуурхай байх зарчимуудыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой бүтээл болжээ.

Энэхүү гарын авлагыг бүтээхэд бүх талын дэмжлэг үзүүлсэн Жайка ОУ-ын төслийн баг, Япон улсын Genepro байгууллага, түүнчлэн Орхон аймгийн ЭМГ-ийн НЭМТ, БОЭТ-ийн хамт олон, сургалтын алба, ялангуяа төслийн зөвлөхөөр хамтран ажилласан Мурохара Хомарэ эмчид чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Сайн үйлс дэлгэрэх болтугай

**Орхон аймгийн БОЭТ-ийн захирал,
Мэс заслын тэргүүлэх зэрэгтэй, эмнэлзүйн сургагч багш,
Клиникийн профессор Б.Батсүх**

ГАР УГААХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ ЗААВАР

Нэг. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

1.1. Гарын эрүүл ахуй сахилт нь халдвараас сэргийлэхэд хамгийн чухал бөгөөд энгийн арга тул энэхүү зааврыг эрүүл мэндийн байгууллагын ажилтан, дадлагажигч эмч, оюутан, үйлчлүүлэгч түүний асран хамгаалагчид дагаж мөрдөнө.

1.2. Эрүүл мэндийн байгууллага нь гар угаах халуун, хүйтэн ус бүхий угаалтуур, шингэн саван, гар арчих зориулалтын нэг удаагийн цаасан алчуур, гар халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байна.

1.3. Мэс засал, төрөх, нярай, тарианы зэрэг ажилбар хийгдэх өрөөний гарын угаалтуур нь хөл, тохойгоор ажилладаг эсвэл мэдрэгчтэй байна.

1.4. Төвлөрсөн усан хангамжгүй газарт гоожуурт угаалтуурыг ашиглаж болно. Ус нөөцлөх сав нь цэвэр, ус бохирдохоос сэргийлсэн тагтай байна.

1.5. Гарын угаалтуур нь ажилбарын цэг, цэвэр хэсгээс 1 метрээс багагүй зайд байна. Гар угаах явцад ус цацагдах нь эмнэлгийн орчинд бичил биетний тархалтыг нэмэгдүүлдэг тул тосгуур хэт жижиг биш, гүн байна. Угаалтуурын цоргоноос тосгуурын гүн хүртэлх зай 26 см-ээс ихгүй байна.

1.6. Угаалтуурын арын ханын хэсэг ус нэвтрэхгүй, цэвэрлэх боломжтой материалаар хийгдсэн байна.

1.7. Гарыг ундны усны стандартын шаардлага хангасан, бүлээн усаар угаана.

1.8. Угаалтуур бүрт гарын шингэн саван, нэг удаагийн цаасан алчуур, хогийн савыг байршуулна.

1.9. Эрүүл мэндийн байгууллагад спиртийн агууламж нь 70-80 хувь, арьсыг хуурайшуулахаас сэргийлсэн зөөлрүүлэгч бодистой, эрх бүхий байгууллагаас олгосон бүртгэл, зөвшөөрөлтэй гар халдваргүйжүүлэх бодис хэрэглэнэ.

1.10. Гар халдваргүйжүүлэх бодисыг тусламж, үйлчилгээний цэг бүрт, халдварын эрсдэл өндөртэй тасаг нэгжийн үүдэнд, үйлчлүүлэгчийн орны дэргэд хэрэглэхэд ойр байрлуулна.

1.11. Гар угаах дараалал, санамж, анхааруулга бүхий зурагт хуудсыг гарын угаалтуур болон тусламж, үйлчилгээний цэгүүдэд байрлуулсан байна.

1.12. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй тасаг, нэгжүүдэд давтан арчдаг даавуун алчуур, гар хатаагч сэнсийг ашиглахгүй.

1.13. Эрүүл мэндийн ажилтан жилд 1-ээс доошгүй удаа гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг баталгаажуулах сургалтанд хамрагдана.

1.14. Гар халдваргүйжүүлэх бодис арьсыг хэт хуурайшуулах, харшил өгч байгаа нь тогтоогдвол бодисыг солих арга хэмжээ авна.

1.15. Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдал, гар халдваргүйжүүлэх бодисын хэрэглээнд улирал тутам, эрүүл мэндийн ажилтны мэдлэг, дадал, гарын эрүүл ахуй сахилтын ажиглалтын үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.

Хоёр. Эрүүл мэндийн ажилтны үүрэг

1.1. Эрүүл мэндийн ажилтан гарын эрүүл ахуй сахих 5 заалтыг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

1.1.1. Үйлчлүүлэгчид хүрэхийн өмнө,

1.1.2. Үйлчлүүлэгчид хүрсний дараа,

1.1.3. Ариун ажилбар гүйцэтгэхийн өмнө,

1.1.4. Биологийн шингэнд хүрсний дараа

1.1.5. Үйлчлүүлэгчийн эргэн тойрон, орчны эд зүйлст хүрсний дараа гарын эрүүл ахуйг сахина.

1.2. Гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг зөв эзэмшинэ.

1.3. Гар угааж, халдваргүйжүүлсний дараа орчны гадаргуу, хийх ажилбараас бусад зүйлд хүрч гараа бохирдуулахаас сэргийлнэ.

1.4. Дараах тохиолдолд эрүүл мэндийн ажилтан ус, шингэн саван ашиглан гар угаана.

1.4.1. Нүдэнд харагдахуйц бохир;

1.4.2. Биологийн шингэнээр бохирлогдсон;

1.4.3. Бээлий тайлсны дараа;

1.4.4. Норовирус, ротавирус, гепатитийн А вирус зэрэг бүрхүүлгүй вирус болон *C.difficile*, спортой бактерийн халдварын сэжигтэй болон батлагдсан үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх.

1.5. Бусад тохиолдолд спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодисоор халдваргүйжүүлнэ. Гар угаасны дараа спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодис ашиглаж болно.

1.6. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажилтны гарын хумс 0.2см–ээс урт биш, будаггүй, хиймэл хумсгүй, бөгж, бугуйвч, бугуйн цаггүй байна.

1.7. Гар халдваргүйжүүлэх бүтээгдэхүүн арьсыг хэт хуурайшуулах, харшил өгч байгаа тохиолдолд тасаг нэгжийн эрхлэгч, тархвар судлаач, халдварын сэргийлэлт, хяналтын ажилтан, алба, багт мэдэгдэнэ.

1.8. Шингэн саван, цаасан алчуур байхгүй, угаалтуур эвдэрсэн зэрэг гар угаах нөхцөл хангагдаагүй бол байгууллагын санхүү, аж ахуйн албанд мэдэгдэнэ.

Гурав. Гар угаах, халдваргүйжүүлэх арга

3.1. Ус саван ашиглаж угаахдаа гараа норгосны дараа шингэн саванг хангалттай хэмжээгээр авна. Гар халдваргүйжүүлэхдээ спиртэн суурьтай бодисоос алганы хонхорыг дүүртэл буюу 3 мл орчмыг авна.

3.2. Саван, ус ашиглаж угаах болон гар халдваргүйжүүлэхдээ **дараах үйлдлүүдийг бүрэн гүйцэтгэнэ.**

- Саван болон халдваргүйжүүлэх бодисыг гарын гадаргууд жигд тараана;
- 2 гарын алга болон хурууны завсар хооронд үрэх;
- Нэг гарын алгаар нөгөө гарын ар талыг үрэх;
- Хурууг үеэр нугалж нөгөө гарын алган дотор хурууны үзүүр, хумс, үений хэсгийг үрэх;
- Алганы хонхорыг нөгөө гарын хурууны үзүүр хэсэгтэй хооронд нь үрэх;
- Эрхий хурууг нөгөө гарын алган дотроо эргэлдүүлэх хөдөлгөөнөөр үрэх;
- Гарын бугуй үрэх.

3.3. Гар угаах хугацаа 1 минут, халдваргүйжүүлэх хугацаа 20-30 секундээс багагүй байна.

3.4. Гараа угаасны дараа усаар зайлж саванг арилгаад нэг удаагийн цаасан алчуураар арчина. Угаагуурын ус гар оролцож хаагддаг бол крантыг цаасан алчуураар жийрэглэж хаана.

3.5. Шингэн саван, гар халдваргүйжүүлэх бодисыг дууссаны дараа савыг сайтар цэвэрлэж, хатаана. Дуусаагүй байхад нэмж хийхийг хориглоно.

3.6. Гар нойтон байхад спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх бодисыг хэрэглэхгүй.

3.7. Гар халдваргүйжүүлэх бодисыг ашиглаж эхлэхдээ нээсэн огноо, савалж хэрэглэдэг бол дахин савласан огноог тэмдэглэнэ.

3.8. Хэрэглээний явцад спиртын агууламжийг тодорхойлж, шаардлага хангаж буй эсэхэд эм зүйч, эм найруулагч дотоодын хяналт тавина.



ГАРАА ТОГТМОЛ ЗӨВ УГААХ НЬ ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ХАМГИЙН ҮР ДҮНТЭЙ АРГА ЮМ.



1 ГАРЫГ бугуй хүртэл жигд норгоно.



2 Саван болон халдваргүйжүүлэх бодисыг гарын дотор, гадна гадаргууд жигд тараана.



3 2 гарын алга болон хурууны завсар хооронд үрнэ.



4 Нэг гарын алгаар нөгөө гарын ар талыг үрнэ.



5 Хурууг үеэр нугалж нөгөө гарын алган дотор хурууны үзүүр, хумс үений хэсгийг үрнэ.



6 Алганы хонхорыг нөгөө гарын хурууны үзүүр хэсэгтэй хооронд нь үрнэ.



7 Эрхий хурууг нөгөө гарын алган дотроо эргэлдүүлэх хөдөлгөөнөөр үрнэ.



8 ГАРЫН бугуй үрнэ



9 Гараа угаасны дараа усаар зайлж саванг арилгаад нэг удаагийн цаасан алчуураар арчина. Угаагуурын ус гар оролцож хаагддаг бол крантыг цаасан алчуураар жийрэглэж хаана.



10 ГАР УГААХ хугацаа нэг минут халдваргүйжүүлэх хугацаа 20-30 секундээс доошгүй байна.

ГАР ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ БОДИСЫГ ХЭРЭГЛЭХ АРГА

- Нэг гарынхаа алган дээр 2 дулаас хэтрэхгүй дусаах
- Хоёр гарын алгаа хооронд нь үрэх
- Гараа тойруулан үрэх /хуруунуудын завсар хоорондыг үрэх/
- Хурууны үзүүрийг алгаараа тойруулан ариутгана.

Дөрөв. Мэс ажилбарын үеийн гар угаах, халдваргүйжүүлэлт:

4.1. Мэс заслын өрөөний угаалтуур нь хөл, тохойгоор ажилладаг эсвэл мэдрэгчтэй, зэвэрдэггүй ган материалаар хийгдсэн байна. Тосгуур нь тохой хүртэл гар угаахад шүргэхээргүй, ус цацагдахааргүй том хэмжээтэй байна. Угаалтуурын ханын хэсэг нь ус нэвтэрдэггүй, цэвэрлэхэд тохиромжтой материалаар хийгдсэн байна.

4.2. Гар угаах хөөсрүүлэгч материал, саван, ариун алчуур, халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байна.

4.3. Гар угаах, халдваргүйжүүлэх бодис нь мэс заслын гар угаалтад зориулагдсан байна.

4.4. Гар угаах усны хэм, урсгалыг тохируулан тохойноос урагш хэсгийг сайтар норгосны дараа нэг удаагийн хэрэглээний губка ашиглан гарын алга, ар тал, хуруунуудын завсар, хумс, бугуйнаас тохой хүртэл сайтар үрж 5-аас багагүй минутын турш угаана.

4.5. Цэвэр усаар булхуулж саванг бүрэн гүйцэт арилгасны дараа арчиж хатаана.

Тав. Хяналт, үнэлгээ

1.1. Эрүүл мэндийн байгууллага нь гар угаах, халдваргүйжүүлэх зааврын хэрэгжилтэд хавсралт дахь үнэлгээ хийх загвар хуудасын дагуу дотоодын хяналт, үнэлгээ хийнэ. Үүнд:

- 5.1.1. Гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдалд жилд 2-оос доошгүй удаа;
- 5.1.2. Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадлыг бүх ажилтныг хамруулан жилд 1-ээс доошгүй удаа;
- 5.1.3. Гарын эрүүл ахуйг сайжруулах талаар байгууллагын үйл ажиллагааг жил тутам;
- 5.1.4. Гарын эрүүл ахуй сахилтын ажиглалтын үнэлгээнд тусламж, үйлчилгээнд оролцон ажилладаг эрүүл мэндийн ажилтанг хамруулан жилд 1-ээс доошгүй удаа;
- 5.1.5. Гар халдваргүйжүүлэх спиртэнд суурилсан бодисын хэрэглээний байдлыг улиралд 1-ээс доошгүй удаа тус тус үнэлнэ.

5.2. Хяналт, үнэлгээг сургалтанд хамрагдсан, дадлага, туршлагатай мэргэжилтэн хийж, үнэлгээний дүнг эргэн мэдээлдэг байна.

5.3. Үнэлгээний дүнгийн дагуу үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллана.

ГАР УГААХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ЗАГВАР ХУУДАС

Огноо:

Тасаг, өрөөний нэр:

Үнэлгээ хийсэн хүний нэр:

Бүх асуултанд хариулж Тийм, Үгүй тохирох нүдэнд тэмдэглэнэ.

	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
1	Хэвийн ажиллагаатай (эвдрэл гэмтэлгүй) угаалтууртай эсэх			
2	Угаалтуур нь хөл, тохойгоор ажиллах боломжтой эсэх эсвэл мэдрэгчтэй эсэх			
3	Угаалтуурын дэргэд шингэн савантай эсэх			
4	Угаалтуурын дэргэд зориулалтын цаасан алчууртай эсэх			
5	Гар угаах ус нь цэвэр эсэх			
6	Шингэн савангийн сав нь цэвэр эсэх			
7	Угаалтуур цэвэр, угаалтуур дотор ямар нэгэн багаж хэрэгсэл хийгээгүй байх			
8	ЭМА гартаа бөгж, бугуйвч, бугуйн цаг зэрэг гоёл чимэглэлгүй, хумс ургуулаагүй, хумс будаагүй, хиймэл хумсгүй байх			
9	Гар угаах санамж бүхий зурагт хуудастай эсэх			
10	Тусламж, үйлчилгээний цэг бүрт гар халдваргүйжүүлэх бодистой байх			
11	Гар халдваргүйжүүлэх бодисын спиртын агууламж 70-80 хувь байх			
12	Гар халдваргүйжүүлэх бодис нь тунлагч, шахуурга бүхий зориулалтын савтай байх			
13	Гар халдваргүйжүүлэх бодисын сав цэвэр эсэх			
14	Гар халдваргүйжүүлэх бодисыг ашиглаж эхэлсэн хугацааг тэмдэглэсэн эсэх			

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ГАР УГААХ, ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ МЭДЛЭГ, ДАДЛЫГ ҮНЭЛЭХ ЗАГВАР ХУУДАС

Огноо:

Үнэлгээнд хамрагдсан ажилтны нэр:

Үнэлгээ хийсэн хүний нэр: -----

Бүх асуултанд хариулж Тийм, Үгүй тохирох нүдэнд тэмдэглэнэ.

	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
1	Гарын эрүүл ахуй сахиx 5 мөчийг нэрлэж чадаж байна уу			
2. Гар угаах, халдваргүйжүүлэх үйлдлийг шалгах				
2.1.	Гар халдваргүйжүүлэх бодис эсвэл шингэн саванг гарт бүрэн тараах			
2.2	Гарын алга, хуруу хооронд үрж угаах			
2.3	Хоёр гарын ар талыг үрж угаах			
2.4	Хоёр гарын хурууг үеэр нугалж алга дотроо үрж угаах			
2.5	Алганы хонхорыг нөгөө гарын хурууны өндгөөр үрж угаах			
2.6	Эрхий хурууг алга дотор үрж угаах			
2.7	Бугуй угаах			
3	Гараа цэвэр усаар саванг арилтал зайлсан			
4	Угаасан гараа крантад хүргэлгүйгээр усаа хаасан			
5	Нэг удаагийн цаасан алчуураар арчиж хатаасан.			
6	Гар угаахад угаалтуурын тосгуурт гар хүрэлцээгүй			
7	Гар халдваргүйжүүлсний дараа бодис бүрэн шингэсэн			
8	Гар угаахад 1 минутаас багагүй хугацаа зарцуулсан			
9	Гар халдваргүйжүүлэхэд 20-30 секунд зарцуулсан			

ГАРЫН ЭРҮҮЛ АХУЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ЗАГВАР ХУУДАС

Огноо:

Үнэлгээнд хамрагдсан эмнэлгийн нэр:

Үнэлгээ хийсэн хүний нэр: -----

Бүх асуултанд хариулж Тийм, Үгүй тохирох нүдэнд тэмдэглэнэ.

	Асуултууд	Тийм	Үгүй	Тайлбар
1	Төвлөрсөн усан хангамжтай эсэх			
2	Угаалтуур орны харьцаа. Тасгуудад хамгийн багадаа 1:10; Тусгаарлах өрөө болон сэхээн амьдруулах өрөөнд 1:1 байх			
3	Байгууллагын төлөвлөгөөнд гарын эрүүл ахуйг сайжруулах үйл ажиллагаа тусгасан			
4	Хэрэгцээг тооцож төсөвт тусгасан эсэх			
5	Гарын эрүүл ахуйн сургалт хийх сургагдсан мэргэжилтэн байгаа эсэх			
6	Бүх ажилтанг гарын ахуйн сургалтад хамруулж баталгаажуулсан эсэх			
7	Шинэ ажилтанд мэдлэг, дадал олгох сургалт хийдэг эсэх			
8	Гарын эрүүл ахуй сахих ажиглалтын үнэлгээнд тусламж, үйлчилгээнд оролцож байгаа ажилтанг бүрэн хамруулсан (хамгийн багадаа жилд 1 удаа)			
9	Ажиглалтын үнэлгээ хийдэг ажиглагч сургалтад хамрагдсан эсэх			
10	Ажиглалтын үнэлгээний үр дүнг эргэн мэдээлдэг эсэх			
11	Гар халдваргүйжүүлэх бодисын хэрэглээг хянадаг эсэх (Хамгийн багадаа 3 сар тутамд)			
12	Гарын савангын хэрэглээг хянадаг эсэх (Хамгийн багадаа 3 сар тутамд)			
13	Эмнэлгийн ажилтны гарын эрүүл ахуй сахилтын түвшинг тогтоосон байх			
14	Гарын эрүүл ахуй сахилтын түвшин 70% -иас багагүй байх			
15	Гарын эрүүл ахуй сахих дэлхий нийтийн (5 сарын 5) өдрийг тэмдэглэн ажил зохион байгуулдаг уу ?			

ГАР УГААХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=zFrqMei09qU&feature=youtu.be>

Түлхүүр үг: Gar ugaah


2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Ус саван ашиглаж гар угаахад гарт байх нянгууд, хир, цус болон бусад бохирдлыг цэвэрлэнэ.


Энэ нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх энгийн үр дүнтэй арга юм

Гар угаах хугацаа 1 минутаас доошгүй байна.

ҮЙЛ ЯВЦ



- Гараа усаар сайтар норгоно.



- Гарын бүх гадаргууг угаахад хүрэлцэхүйц саванг авч сайтар үрж хөөсрүүлнэ
- Гарын үр гадаргууг орхигдуулахгүй нь тулд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж болгосон дараалалын дагуу гарыг сайтар угаана



- нэг гарын алганы нөгөө гарын ард байрлуулан гарын ар, алга хуруу хуруунуудын салааг үрж угаана.
- Нөгөө гарыг мөн адил угаана.



- Хоёр гарын алгыг хавсран байрлуулж хуруу хооронд үрж угаана



- Нэг гараа атгаж нөгөө гарын хурууны үеүдийг үрж угаана.
- Нөгөө гарыг мөн адил угаана.



- Нэг гарын эрхийн хурууг нөгөө гараараа атгаж алгандаа эргүүлэх хөдөлгөөнөөр угаана.



- Нэг гарын алгандаа нөгөө гарын үзүүрүүдийг үрж угаана.



- Хурууны үзүүрүүдийг угаасны дараа хоёр гарын бугуйг ээлжлэн угаана.



- Гарыг усаар зайлж угаана.



- Гарыг нэг удаагийн алчуураар арчиж хатаана



- Гоожуурын цоргыг тохойгоороо дарж хаана.
- Эргүүлж хаадаг бол нэг удаагийн цаасаар жийргэлж хаана.



ЭМНЭЛГИЙН ХУВЦАС ӨМСӨХ АРГА



Өдөр тутмын хамгаалах хувцас Дүрс бичлэг үзэх:


1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=QML5i0ADkMg&t=12s>

Түлхүүр үг: [emnelgiin huvtsas](#)

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчийн халдварт өртөх эрсдлийг бууруулахын тулд хамгаалах хэрэгсэлийг зөв, зохистой хэрэглэх хэрэгтэй.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд өдөр тутам хэрэглэгддэг нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл



Хэрэглэгдэх зүйлс:

- Халад
- Бээлий
- Амны хаалт
- Малгай

ҮЙЛ ЯВЦ



- Хамгаалах хувцас хэрэглэлийг өмсөхийг өмнө гарын ариун цэврийг сахина.



- Эхлээд халад өмсөнө. Халад нь биеийн хэмжээнд тохирсон, хөдөлгөөнд саад учруулахгүй байх ёстой
- Шингэн нэвчих эрсдэлтэй үед усны хамгаалалттай хормогчийг давхарлан өмсөнө.



- Халадаа өмссөний дараа амны хаалтыг зүүнэ.
- Амны хаалт нь ам хамрын салстыг хамгаалах үүрэгтэй.
- Эмнэлгийн ажилтан ярих, ханиах, найтаах үед хамар амнаас бичил биетэн гадагшилж үйлчлүүлэгчид халдвар дамжих эрсдлийг бууруулдаг.
- Амны хаалтыг зүүхдээ амны хаалтны доод ирмэгийг хэсгийг эрүүний доор байрлуулаад дээд ирмэгт байх метал хэсэгт дарж хамрын хэлбэрт тохируулна.



- Малгайг өмсөхдөө үсийг бүрэн далдалж өмсөнө.



- Нэг удаагийн үзлэгийн бээлийг өмсөхийн өмнө гарыг дахин халдваргүйжүүлнэ.



- Бээлийний бүрэн бүтэн байдлыг заавал шалгана.



- Бээлийг халадны ханцуйг даруулж өмсөнө.



Тайлах үйл явц

- Хамгаалах хувцас хэрэглэлтэй тусламж үйлчилгээ үзүүлсний дараа хамгаалах хувцас хэрэглэлийн урд талын гадна хэсэг илүү бохирдсон байдаг тул урд талын гадна хэсэгт хүрэхээс зайлсхийж тайлах нь чухал.



- Эхлээд бээлийг тайлна.
- Бээлийг тайлахдаа нэг гараараа нөгөө гарын бээлийний бугалганы хэсгийн гадна талаас чимхэн татаж тайлан тайлсан бээлийг бээлийтэй гарт атгана
- Нөгөө гарын бээлийг тайлахдаа бээлийгүй гарын нэг хурууг нөгөө гарын бээлийний бугуйн хэсгийн дотор тал руу нь шургуулж дотор талыг гадагш нь эргүүлж тайлаад халдвартай хог хаягдал цуглуулах саванд хаяна.



- Гараа ариутгана.



- Үүний дараа халадаа тайлахдаа дээд дунд бүчийг тайлсны дараа 2 гараа зөрүүлэн мөрний хэсгээс барин татаж галана талыг дотогш эргүүлж, дээрээс нь доош нь хуйлж тайлаад халдвартай хог хаягдлыг цуглуулах саванд хийнэ



- Малгайг ар талаас дотогш эргүүлэн тайлна.



- Дараа нь амны хаалтыг тайлж халдвартай хог хаягдлыг цуглуулах саванд хаяна.



- Төгсгөлд нь гарын эрүүл ахуйг дахин сахина

ОНЦГОЙ НӨХЦӨЛД ХАМГААЛАХ ХУВЦАС, ХЭРЭГСЭЛ ӨМСӨХ АРГА:



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
https://www.youtube.com/watch?v=XUlj3x_ph_I&t=74s

Түлхүүр үг: ontsgoi emnelgiin huvtsas

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Эрүүл мэндийн ажилтан болон үйлчлүүлэгчдийн халдварт өртөх нөхцөлийг буруулахын тулд хамгаалах хувцас хэрэглэлийг зөв зохистой хэрэглэх хэрэгтэй

Агаар дуслын замаар дамждаг, олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг халдвар уушгины хэлбэрийн тарваган тахлын өмнө эдгээр хувцас хэрэглэлийг өмсөнө.



ХАМГААЛАЛТЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ ӨМСӨХ ҮЙЛ ЯВЦ



- Хамгаалах хувцас хэрэглэлийг өмсөхийн өмнө гарын эрүүл ахуйг сахиж дотор бээлийг эхлээд өмсөнө.



- Үүний дараа нэг удаагийн комбинзоныг өмсөнө. Комбинзон нь биеийн хэмжээнд тохирсон хөдөлгөөн саад учруулахгүйгээр байх



- Комбинзон нь гутлын гадуур углааштай бол гутлын дээрээс шууд өмсөнө.
- Гутлын гадуур углаашгүй бол усны гутал өмсөж комбинезоны түрүүг усны гутлын гадуур гаргаж өмсөнө.



- Дараа нь эмнэлгийн зориулалттай шүүлтүүртэй амны хаалтыг зүүнэ.
- Зүүхдээ амны хаалтын аяга хэсгийг гарын алган дотор байрлуулж хоёр бүчийг доош унжуулан барина.



- Алгандаа байрлуулсан амны хаалтыг ам хамрын хэсэгт тохируулан барьж доор бүчийг дагзны доор, дээд бүчийг толгойн оройн хэсэгт татаж байрлуулна.
- Амны хаалтын доод хэсгийг эрүүний доогуур байрлуулж, дээд хэсгийн металл дээр дарж хамрын хэлбэрт тохируулна. Амны хаалтын тохироог заавал шалгана.



- Үүний дараа зориулалтын нүдний шилийн зүүнэ. Нүдний шил нь зай завсар гаргахаас сэргийлсэн зөөлөвчтэй байна.
- Нүдний доод хэсэг нь амны хаалтын дээд хэсгийг дарсан байна.



- Амны хаалт нүдний шилийг зүүсний дараа комбинзоны малгайг өмсөж цахилгааныг гүйцээж татна.
- Шингэн ихтэй ажилбарын үед усны хамгаалалттай хормогчийг давхарлан өмсөж болно.



- Дараа нь гадна бээлийг өмсөхдөө комбинзоны ханцуйг даруулж өмсөнө.
- Комбинзоны ханцуйг сугарч гарах эрсдэлээс сэргийлж комбинезоны ханцуй дээр цоолж эрхийн хуруугаа углаж өмсөж болно.

ХАМГААЛАЛТЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ ТАЙЛАХ ҮЙЛ ЯВЦ



- Хамгаалах хувцас хэрэгсэлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсний дараа хамгаалах хувцас хэрэглэлийн урд талын гадна хэсэг илүү бохирдсон байдаг учир урд талын гадна хэсэгт хүрэхээс сэргийлж тайлах нь чухал.
- Усны гутлыг халдваргүйжүүлэх бодистой уусмалд дүрж гадна талыг халдваргүйжүүлнэ.



- Бээлийг тайлахдаа нэг гараар нөгөө гарын бээлийн бугалга хэсгийн гадна талаас чимхэн тайлан бээлийтэй гарт атгана



- Нөгөө гарын бээлийг тайлахдаа бээлийгүй гарын хурууг бээлийн дотор шургуулж дотроос гадагш эргүүлж тайлан халдвартай хог хаягдлыг цуглуулах саванд хаяна.



- Комбинзоныг тайлахдаа комбинзоны цахилгааны доошлуул удаан хөдөлгөөнөөр сэгсрэлгүй дотор талыг гадагш эргүүлэн дээрээс доош хуйлж тайлан халдвартай хог хаягдлыг цуглуулах саванд хаяна.



- Дотор бээлийг гадна бээлий тайлсан аргачлалаар тайлан гарын эрүүл ахуйг сахина.



- Нүдний шилийг тайлахдаа доош хагас бөхийн шилний бүчнээс татаж тайлна. Гараа дахин халдваргүйжүүлсний дараа амны хаалтыг тайлна.



- Амны хаалтыг тайлахдаа доош хагас бөхийн толгойн ар хэсэгт хоёр бүчийг нийлүүлэн барьж татаж тайлна.
- Усны гутлаа тайлна



- Төгсгөлд нь гарын эрүүл ахуйг дахин сахина

АМЬСГАЛЫН ЗАМ ЧӨЛӨӨЛӨХ ЭНГИЙН АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=tHSU28Yt6K8>

Түлхүүр үг: Амьсгалын зам чөлөөлөх энгийн арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Амьсгал зүрх судасны үйл ажиллагааг шалгаад ухаангүй байгаа тохиолдолд амьсгалын замыг чөлөөлөн, хэвийн амьсгалах нөхцлийг хангах

Зорилт:

- Амьсгалын замын саадыг илрүүлэх
- Амьсгалын замыг чөлөөлөх үндсэн аргуудыг эзэмших

Амьсгалын зам бөглөрөх шалтгаан: Амьсгалын зам хагас буюу бүрэн бөглөрсөн байж болно. Бөглөрөл нь хамар амнаас мөгөөрсөн хоолой хүртэл амьсгалын дээд замын аль ч түвшинд тохиолдож болох юм. Мөн бөглөрөл нь бөөлжис, цус болон гадны биетээр үүсч болно. Амьсгалын дээд зам цочирсноос төвөнхийн агчил үүсдэг.

Амьсгалын зам чөлөөлөх шалтгаан:

- Зүрх зогсох, ком, гэмтлийн үед → хэл арагшилж таглах
- Анафилакси, гадны биет, түлэх бодисын үйлчлэлээр → хэл хавагнах, ам залгиур бөглөрөх, төвөнх агчих
- Гадны биетээр бөглөрөх → төвөнх, мөгөөрсөн хоолой бөглөрөх
- Гэмтлийн галтгаанаар → төвөнх гэмтэх
- Халдвар, анафилакси үед → төвөнх хавагнах
- Гуурсан хоолойн багтраа, гадны биет, анафилакси үед → гуурсан хоолойн агчих
- Түлэх бодис, халдвар, живэх, мэдрэлийн шокийн үед → уушиг хавагнах



Анхаарах зүйл:

- Хүзүүний яс гэмтсэн сэжиг бүхий /өндрөөс унасан, хүзүү толгойн илэрхий гэмтэлтэй, усанд живсэн/ хүмүүст анхны тусламж үзүүлэх үед толгой, хүзүү, цээж, бүсэлхий нурууг эгц, хөдөлгөөнгүй байрлуулна.
- Толгойг их хөдөлгөж, гэдийлгэвэл хүзүүний гэмтлийг хүндрүүлж нугасыг гэмтээх осолтой.
- Хүчилтөрөгчийн дутагдал, зүрхний үйл ажиллагааны дутмагшил, цус алдах хандлагатай, гавлын дотоод даралт ихэссэн өвчтөнд анхаарал болгоомжтой хийх

Хэрэглэгдэх зүйлс:

- Ам-залгиурын гуурс
- Хамар-залгиурын гуурс
- Гар халдваргүйжүүлэх уусмал
- Гель
- Пульсоксиметр
- Чагнуур
- Амбу
- Сальфетка
- Бээлий, маск



Амьсгалын замын бөглөрлийг таних: Тусламж үзүүлэгч осолдогчийн толгойн хэсгийн аль нэг талд зогсон цээжээрээ тонгойн, толгойгоо хажуу тийш эргүүлэн, чихээ осолдогчийн хамарт ойртуулан амьсгалж буйг чагнах, мэдрэх ба энэ үедээ нүдээрээ цээжний хөдөлгөөнийг давхар харж ажиглан үнэлнэ.

- Ажигла - Цээж ба хэвлийн хөдөлгөөнийг ажиглах
- Чагна - Ам, хамраар амьсгалсан агаар гарч байгааг чагнах

Амьсгалын зам хагас бөглөрөхөд ямагт шуугисан чимээ гарна. Хорчигнох, хурхирах, хяхнах зэрэг амьсгалын өвөрмөц чимээнүүдийг ялгаж, амьсгалын замын бөглөрлийн шалтгааныг илрүүлэх. Чагналтаар амьсгалын шуугиан сонсогдохгүй бол амьсгалын замын бүрэн бөглөрлийг үгүйсгэх шаардлагатай.


- Мэдэр - Ам, хамраар гарах агаарын урсгалыг мэдрэх

Амьсгалын замыг чөлөөлөх анхны арга хэмжээ: Амьсгалын замын бөглөрлийн шинж илэрсэн бол амьсгалын замыг яаралтай чөлөөлнө.

Амьсгалын дээд замыг чөлөөлөх 2 барил нь:

- Толгой гэдийлгэн, эрүүний шонтоогоос өргөх
- Эрүүний булангаас түлхэх

ТОЛГОЙ ГЭДИЙЛГЭН, ЭРҮҮНИЙ ШОНТОГООС ӨРГӨХ БАРИЛ:



Нэг гараараа духан дээр нь дарж, толгойг нь зөөлөн гэдийлгэн, нөгөө гарын хуруунуудаар эрүүний шонтоогоос өргөнө.

Эрүүг булангаас түлхэх барил (хүзүүний гэмтлийн сэжигтэй үед):




Тусламж үзүүлэгч нь гарын 4 хурууг эрүүний өнцгийн ардаас дарж урагш, дээш түлхэнэ. Хоёр гарын эрхий хуруугаар эрүүний урд хэсгийг бага зэрэг хөшиж амыг нь ангайлгана.



Энэ үед тусламж үзүүлэгч нь толгой, хүзүүг хөдлөлгүй түшиж барих хэрэгтэй!!!

Амьсгалын замыг чөлөөлөхөд туслах хялбар хэрэгслүүд



Ам-залгиурын гуурс нь нярай хүүхдээс эхлэн насанд хүрэгсдэд тохирох тус тусын хэмжээтэй байдаг. Насанд хүрсэн хүмүүст ам-залгиурын гуурснаас 2, 3, 4 гэсэн хэмжээтэйгээс тохирох гуурсыг хэмжээг нь авч сонгоно.

АМ-ЗАЛГИУРЫН ГУУРСЫГ АМЬСГАЛЫН ЗАМД БАЙРЛУУЛАХ:



Ам-залгиурын гуурсны уртыг тухайн өвчтөний үүдэн шүднээс эрүүний булан хүртэлх хэмжээгээр тохируулж авна.



Тусламж үзүүлэгч нь нэг гараараа эрүүг өргөн амыг ангайлган, нөгөө гарын эрхий болон долоовор хуруугаар ам залгиурын гуурсны үзүүрийг зөөлөн тагнай чигтэй ам руу хийнэ.

Эрүү зуурсан тохиолдолд ам тэлэгчийг ашиглан ам залгиурын гуурсыг тавьж болно.



Ам-залгиурын гуурсыг зөөлөн тагнай чигтэй хийх үед тагнай орчим тулах үед ам-залгиурын гуурсыг 180° эргүүлэн цааш бага зэрэг түлхэж, хэлний угт амны хөндийд байршуулан, амьсгал чөлөөтэй эсэхийг шалгаж үзнэ (Амбугаар).



Ам-залгиурын гуурс байрлуулсны дараах байдал

Хамар-залгиурын гуурс

Гүн ухаан алдаагүй хүнд хамар-залгиурын гуурс тавих нь ам-залгиурын гуурс тавихаас илүү тохиромжтой байдаг.

Ам нь ангайхгүй, шүд, ам, эрүүний гэмтэлтэй өвчтөнд, ам-залгиурын гуурс хийх боломжгүй үед хамар-залгиурын гуурс тавих нь тохиромжтой. Том хүнд 6-7 мм-ийн гуурс тохирно. Хамраар оруулж тавих үед салст бүрхүүл гэмтэж цус гарч болох ба урт гуурс тавибал хэл залгиурын ба төвөнхийн рефлексийг сэдээж бөөлжих, төвөнх агчих хүндрэл үүсэж болзошгүй.

ХАМАР-ЗАЛГИУРЫН ГУУРСЫГ БАЙРЛУУЛАХ АРГАЧЛАЛ:



Энэхүү аргыг амны хөндийд шархтай, ам залгиурын гуурс тавих боломжгүй үед хэрэглэхэд илүү тохиромжтой.

Хамрын угалзаас чихний омог хүртэл гуурсыг барьж хэмжээс авна.



Гуурсны үзүүрт гель түрхнэ.



Толгойг гэдийлгэнэ

Хамрын хөндийг шалгаж, цэвэрлэнэ.

Гуурсыг хамрын нүхэнд тэгш өнцгөөр хийнэ.

Гуурсыг хуруугаараа зөөлөн дарж оруулна.

Хажуугийн сэргээх тогтвортой байрлал:

Өвчтөн ухаангүй боловч амьсгалын зам нь саадгүй тохиолдолд тохирох байрлал юм. Энэ байрлал нь тогтвортой, цээжинд даралт учруулахгүй, толгой доор, чөлөөтэй амьсгалах боломжийг олгохуйц байна.



Өөртөө ойр байгаа гарыг нь тэгш өнцгөөр тэнийлгэж алгыг нь дээш харуулан тохойгоор нь нугална.



Нөгөө гарыг нь цээжин дээгүүр нь давуулж, өөрийн талд байгаа хацарт нь хүргэнэ



Нөгөө гараараа дээд талын хөлийг өвдгөөр нь нугалж доод талын хөлний дээгүүр нь давуулан шилбэ, тавхайг нь газарт хүртэл татна.



Хажуугийн сэргээх тогтвортой байрлалд оруулсан байдал.

Амьсгал жигд байгаа эсэхийг шалгана.

Өвчтөн энэ байрлалд 30 минутаас илүү байвал доод гарын дарагдлыг чөлөөлөхийн тулд нөгөө хажуугаар нь эргүүлж дээрхтэй адил байрлалд оруулна

Ажилбарын дараа:

- Бээлийгээ тайлах
- Гараа угаах
- Хэрэглэгдэх зүйлсээ хураах
- Анхан шатны бичиг баримтаа хөтлөх
- Үйлчлүүлэгч болон ар гэрийхэнд нь ажилбар дууссан тухай тайлбарлаж өгөх
- Амин үзүүлэлтүүдийг үзэж, биеийн байдлыг ажиглах

ЦЭР САЛСТЫГ СОРУУЛАХ

Амьсгалын дээд замаас шингэн /цус, шүлс, ходоодны агуулагдахуун/-ийг өргөн голчтой, үл нугарах гуурсаар соруулж цэвэрлэнэ.



Анхаарах зүйл: Өвчтөн огих рефлекс тэй байвал соруулах үед бөөлжиж болох тул болгоомжтой ажиллах хэрэгтэй. Соруулах хугацаа нэг удаад 20 секундээс илүүгүй хугацаагаар соруулах

Хэрэглэгдэх зүйлс:

1. Соруулгын аппарат, аппаратны залгуур, шил
2. Янкур гуурс
3. Соруулгын гуурс
4. Бээлий
5. Гар халдваргүйжүүлэх уусмал
6. Халад, малгай, маск
7. Нэрмэл устай шил

Соруулга хийх арга техник:

Соруулгын аппаратны залгуурыг тогонд залгана. Аппаратны асаах товчийг дарж асаана. Шингэн соруулах шилийг сайн таглаж соруулах бүдүүн гуурстай холбоно. Бүдүүн гуурсыг соруулгын гуурстай холбож шингэн ус соруулан үзэж, ажиллаж буйг шалгана.

- Гараа халдваргүйжүүлнэ.
- Бээлий өмсөх ба шаардлагатай үед малгай маск, халад өмсөнө.
- Соруулалт хийх үед хүчилтөрөгчийн хангамжийг хэмжих хэрэгтэй.
- Хүчилтөрөгчийн хангамжийг үзээд SpO_2 92%-оос бага бол хүчилтөрөгч өгнө.

ҮЙЛДЛИЙН ЯВЦ: Өвчтний толгойг хажуу тал руу болгон долоовор болон дунд хуруугаар амыг ангайлгаж хиймэл шүд, сул шүд, гадны биетийг авч шүлс, цэр салст, бөөлжисийг соруулж авна.

- Соруулгын гуурсны уутыг бээлийгүй гараар шувтран авч, бээлийтэй гараар гуурснаас барина.
- Соруулгын гуурсны үзүүрийг чийглэнэ.
- Өвчтний амыг ангайлган соруулгын гуурсыг хийхдээ тагийг нь таглахгүй хийгээд соруулж эхлэх үед тагийг нь таглана.
- Цэр, салстыг 2-3 удаа соруулна.

Үйлдлийн дараа:

- Соруулж дууссаны дараа соруулгын гуурсыг халдваргүйжүүлж, хаяна.
- Амыг арчин уруулыг тосолно.
- Хүчилтөрөгчийн хангамжийг хянаана.
- Соруулгын аппаратыг салгаж цэвэрлэнэ. Хэрэглэсэн зүйлийг хурааж цэвэрлэнэ.
- Гараа угаана.

ЗҮРХНИЙ ЦАХИЛГААН БИЧЛЭГ ХИЙХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=fknnjv5wZVo>
2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

ЗОРИЛГО:

- Зүрхний өвчнийг оношлох, бусад эрхтэн тогтолцооны эмгэгээс ялган оношлох
- Эмчилгээний явц, үр дүнг хянах

ЗААЛТ: Урьдчилан сэргийлэх үзлэг, өгүүлэмждээ зүрх судасны эмгэгтэй байж болох үйлчлүүлэгчдэд онош тодруулах заалтаар



ЭСРЭГ ЗААЛТ: Үгүй

ХЭРЭГЛЭГДЭХ ЗҮЙЛСИЙГ БЭЛТГЭХ:

- Зүрхний цахилгаан бичлэгийн аппаратын иж бүрдэл
- Арьсыг чийглэх зориулалтын гель
- Бичлэг хийж буй эмч, сувилагчийн өндөрт тохирсон хатуу гадаргуутай ор
- Саван, цэвэр алчуур, спирт (арьсыг тосгүйжүүлэх зорилгоор арчих), үс хусагч
- Ажилбарын дараа гелийг арчих хуурай сальфетка (Зураг 1.)



Зураг 1. Хэрэглэгдэх зүйлс

Бэлтгэл ажил :

- Зүрхний цахилгаан бичлэг хийхээс өмнө үйлчлүүлэгчийг 10-15 минут амраана.
- Үйлчлүүлэгчид электродыг байрлуулахын тулд цээжийг нүцгэлнэ, оймсыг тайлж, өмдний шуудгийг бага зэрэг дээшлүүлж хөлийн шилбийг гаргасан байна.
- Хүзүүний зүүлт, бугуйн дахь цаг зүүлт, бөгж зэрэг металл эдлэлийг биеэс тайлуулж авна.
- Цээжний гадаргууд электродыг нягт наалдуулах зорилгоор тослог ихтэй арьсыг спиртээр арчих ба үсэрхэг бол үсийг савандаж хусна. Арьсыг хуурай болтол арчина.
- ЗЦБ-н аппаратыг үйлчлүүлэгчийн аль нэг талд ойр байрлуулж газардуулагчийг газардуулганд холбоно.
- Залгуурыг тогонд залгана.
- Аппаратны асаах товчийг дарж асаан аппаратыг ажиллаж байгаа эсэхийг шалгана.
- ЗЦБ-н аппаратын дараах өгөгдлүүдийг тохируулна. Үүнд:
 - ✓ Хурд (25 мм/с, 50мм/с, 100мм/с)
 - ✓ Далайц (5mV; 10 mV; 20 mV)
 - ✓ Автоматаар эсвэл гар аргаар бичих эсэх зэргийг тохируулж, цаас бэлэн байгааг шалгана.

ҮЙЛДЛИЙН ЯВЦ:



Зураг 2. Үйлчлүүлэгчийг шинжилгээнд бэлтгэж буй байдал

- Үйлчлүүлэгчтэй мэндлэн, өөрийгөө танилцуулна.
- Хийх гэж буй ажилбарын зорилгыг тайлбарлаж ойлгуулна (Зураг 2).
- Үйлчлүүлэгчийг хатуу гадаргуутай орон дээр биеийг нэг шугаманд байхаар эгц дээш нь харуулж хэвтүүлнэ.
- Үйлчлүүлэгчээс бэлэн эсэхийг асууна.



Зураг 3. Үйлчлүүлэгчийн хөлийн дотор талын шагайны дээд хэсэгт гель түрхэж буй.

- Гараа угаана.
- Бээлий өмсөнө.
- Зүрхний цахилгаан бичлэгийг эхлээд мөчдийн холболтыг дараа нь цээжний холболтыг гэсэн дарааллаар холбоно.
- Мөчдөд электродыг холбохын өмнө гарын бугуйн дотор тал, хөлийн дотор талын шагайны дээд хэсэгт гель түрхэнэ.

- ЗЦБ-ийн аппаратны электродыг мөч болон цээжинд дараах дарааллуудаар тавина. Үүнд:



Дөрвөн мөчдөд:

- Баруун гарт: улаан
- Зүүн гарт: шар
- Зүүн хөлд: ногоон
- Баруун хөлд: хар өнгийн элетродыг тус тус (төмөртэй талыг дотор тал буюу гель түрхсэн хэсэгт) байрлуулна.



- Цээжинд электродыг холбохын өмнө гель түрхэнэ.
- Цэгүүдийг олохын тулд баруун гарын долоовор дунд хуруугаар зөөлөн тэмтэрч мэдэрнэ.

Үүнээс гадна электрод байрлуулах цэгийг (V1) олох хялбар аргыг доор зураг болон тайлбараар үзүүлье:

- Тусламж үзүүлэгч нь үйлчлүүлэгчийн зүүн гар талд нь зогсож, баруун гараараа үйлчлүүлэгчийн өвчүүний баруун ирмэгээр 1-р хавиргыг тэмтэрч олно.
- Өвчүүний баруун ирмэгээр 1-р хавирганы доор, хавирга хоорондын завсарт чигчий хурууны өндгөөр хүрнэ.
- Өвчүүний баруун ирмэгээр 2-р хавирганы доор, хавирга хоорондын завсарт ядам хурууны өндгөөр хүрнэ.
- Өвчүүний баруун ирмэгээр 3-р хавирганы доор, хавирга хоорондын завсарт дунд хурууны өндгөөр хүрнэ.
- Өвчүүний баруун ирмэгээр 4-р хавирганы доор, хавирга хоорондын завсарт долоовор хурууны өндгөөр хүрнэ. Энэхүү хэсэгт V1 электрод байрлуулах цэг олно.



Зураг 4. Электрод байрлуулах цэгийг (V1) олох арга



V1 - Улаан өнгийн электродыг өвчүүний баруун ирмэгээр 4-р хавирганы завсарт

V2 - Шар өнгийн электродыг өвчүүний зүүн ирмэгээр өвчүүний 4-р хавирганы завсарт

V3 - Ногоон өнгийн электродыг 2, 4-р электродын дунд

V4 - Бор өнгийн электродыг зүүн эгэмийн дунд шугамаар 5-р хавирганы завсарт

V5 - Хар өнгийн электродыг зүүн талын суганы урд шугамаар 5-р хавирганы завсарт

V6 - Хөх ягаан өнгийн электродыг зүүн талын суганы дунд шугамаар 5-р хавирганы завсарт тус тус байрлуулна.

- Электродоо байрлуулсны дараа зүрхний үйл ажиллагааны 6-12 мөчлөгийг тасралтгүй бичнэ.
- Print товчыг дарж хэвлэнэ.
- Хэвлэсэн ЗЦБ шаардлага хангасан бол электродыг салгана.
- (Шаардлага хангаагүй бичсэн тохиолдолд бичлэгийг дахин давтана)
- Аппаратаа унтраана.



- Түрхсэн гелийг хуурай сальфеткаар арчиж өгнө.



- Хувцасыг өмсүүлнэ.
- Үйлчлүүлэгчийг босоход нь тусална.

- Үйлчлүүлэгчийн цаг бугуйвч ээмэг бөгж зэрэг эдлэлийг хүлээлгэж өгнө.
- Аппаратны гель болсон хэсгийг арчиж цэвэрлэнэ.
- Аппаратны холболтуудыг эвхэж, хураана.
- Бээлийгээ тайлна.
- Гараа угаана.

Үргэлжлэх хугацаа: 5-7 минут



Анхаарах зүйл: Хөгжлийн бэрхшээлтэй, осголттой гэх мэт ЗЦБ хийхэд хүндрэлтэй үйлчлүүлэгчид мөчдийн холболтыг наалттай электродыг ашиглан их биед холбож болдогийг анхаарах.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч: Эмч, сувилагч

Үйлдлийн гүйцэтгэлд явцын болон эцсийн хяналт тавигч нь: Гүйцэтгэсэн эмч, сувилагч хяналт тавьна.

ХОДООДОНД ХАЙМСУУР ТАВИХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=zwnoNxowMxI>

Түлхүүр үг: Ходоодонд хаймсуур тавих арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Ходоод угаах, хооллох, ходоодны шүүс шинжилгээнд авах

Заалт:

- Ухаангүй, ухаан бүдэгшсэн, залгих чадваргүй хүнд өвчтөн хооллох
- Залгих рефлекс дутуу хөгжсөн эсвэл байхгүй, уруул тагнай сэтэрхий төрсөн
- Амаар хооллох боломжгүй үед (улаан хоолойн залгиур хэсгийн түлэгдэл, ам орчмын мэс засал)
- Хоол боловсруулах замын эрхтнүүдэд мэс засал хийлгэсний дараах үед
- Шинжилгээ, оношилгооны зорилгоор
- Тархины болон бусад хүнд гэмтлүүдийн үед



Эсрэг заалт:

- Ходоод гэдэсний шархлаа
- Улаан хоолойн судасны өргөсөлт, улаан хоолойн нарийсалт
- Ходоод, улаан хоолойн хавдар
- Улаан хоолой, ходоодноос цус алдаж байгаа үед
- Жирэмсний сүүлийн сард

Хэрэглэгдэх зүйлс




1. Хаймсуур - урт 1м, гадна голч 4-5мм, дотор голч 2-3мм, FR14-16
2. Жаньегийн тариур
3. Бээлий
4. Гель
5. Наалдуулагч лент
6. Ам арчих сальфетик
7. Эрүүн дор тавих алчуур
8. Бөөр хэлбэрийн таваг
9. Гар халдваргүйжүүлэх уусмал
10. Чагнуур
11. Хормогч
12. Малгай маск
13. Аяга, ус (хэмжээ нь 40-200 мл, хэм нь 38-40°С)
14. Хог хаягдлын хар шар уут
15. Зажим

Үйлдлийн явц:

- Эмчлүүлэгчтэй мэндэлж өөрийгөө танилцуулна.
- Эмчлүүлэгч болон ар гэрийнхэнд хийх үйлдлээ сайн тайлбарлан ярилцаж, зөвшөөрөл авна.
- Өвчтөнг орон дээр эгц дээш харуулан хэвтүүлж, цээжийг 30-40 хэм өндөрлөж өгнө.
- Гардан үйлдэлд хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж өвчтөнд тайлбарлаж үзүүлнэ.
- Гараа халдваргүйжүүлнэ.
- Бээлий өмсөнө, шаардлагатай үед малгай маск хэрэглэнэ.
- Хормогч зүүнэ.
- Өвчтөнд хормогч зүүлгэнэ.
- Алчуурыг эрүүн дор тавина.
- Бөөр хэлбэрийн тавгийг өвчтний нэг гарт бариулан, амыг усаар зайлуулж, усыг бөөр хэлбэрийн саванд хийлгэнэ.
- Хиймэл шүдтэй бол авахуулж болно.
- Хаймсуурын хэмжээг авна.
- Хаймсуурын үзүүрийн хэсгийг тосолж бэлдэнэ.
- Тусламж үзүүлэгч нь эмчлүүлэгчийн толгой талд зогсож хаймсуурыг баруун гартаа барина.
- Хаймсуурыг амаар ходоодонд тавих үед хаймсуурыг хазах, огих үйлдэл хийхгүй байхыг сануулах, хаймсуур хэлний уг орчим очих үед залгих үйдэл хийлгэж, хаймсуурыг залгих үйлдэлтэй хамт ходоодонд түлхэж оруулна.

Хэмжээг авахдаа хаймсуурын үзүүрээс барьж, амнаас → чихний гэдэс → аймхайн мөгөөрс хүртэл хэмжиж тэмдэглэнэ (Зураг 1).





- Хамраар тавих бол өвчтөнг уртаар амьсгал авахыг зөвлөж, хаймсуур хэлний уг орчим очих үед залгих үйдлэл хийлгэж хаймсуурыг зөөлөн түлхэн, тэмдэг тавьсан хэсэг хүртэл ходоодонд түлхэж оруулна. Өвчтөн ухаантай үед хахаж цацвал хаймсуурыг хүчээр түлхэж болохгүй, дахин хаймсуурыг зөөлөн түлхэж оруулна (**Зураг 2**).
- Хаймсуурын төгсгөлд нь 10 мл хийтэй шприц холбож, чагнуурыг аюулхайд тавин, хийг огцом шахаж, ходоодонд хий орж буй чимээг чагнаж шалгана.
- Ходоодонд хаймсуур орсон тохиолдолд хаймсуурыг наалтаар хамарт нааж бэхэлнэ (**Зураг 3**).
- Тариурыг татаж хаймсуураар гарах зүйлийг хянана.

Үйлдлийн дараа:

- Дахин өвчтний амьсгал, хүчилтөрөгчийн ханамж, судасны цохилтыг хянана. Шаардлагатай бол цусны даралт үзнэ.
- Хог хаягдлаа ангилж ялгана.
- Бээлий тайлна.
- Хэрэглэсэн зүйлсээ хураана.
- Гараа угаана.
- Анхан шатны бичиг баримтанд хийсэн ажилбараа бичиж тэмдэглэн баталгаажуулна.

Гардан үйлдлийг гүйцэтгэгч: Их эмч, сувилагч.

СУДАСНЫ ХҮРЦ БУЮУ УЯН ЗҮҮ ТАВИХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
https://www.youtube.com/watch?v=dMi_LFIDg4Q

Түлхүүр үг: Судасны хүрц буюу уян зүү тавих арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Эмчлүүлэгчид нэг хатгалтаар судсаар эмчилгээг /тарилга, шингэн, цус цусан бүтээгдэхүүн/ үргэлжлүүлэн, 72 цагийн хугацаагаар олон удаагийн эмчилгээг аюулгүй хийхэд оршино. Эмчлүүлэгчийн захын хураагуур судсанд уян зүү тавьж, хатгалтын тоог цөөрүүлэх, найдвартай судсаар эмчлүүлэгчийн эмчилгээг цаг алдалгүй хийх зорилготой.

Заалт:

- Тарилгыг венийн судсанд оруулах
- Ус эрдсийг нөхөх, судсаар тэжээх, алдсан цусыг нөхөх
- Шингэн хурдан хугацаанд сэлбэх
- Яаралтай тусламжийн үед
- Эрчимт эмчилгээ хийх
- Мэс заслын үед
- Хураагуур судас олдоц муу үед
- Биеийн байдал хүнд ба маш хүнд эмчлүүлэгч
- Зарим шаардлагатай тохиолдол бүрт



Эсрэг заалт:

- Цусны бүлэгнэлтийн тогтолцооны өөрчлөлттэй эмчлүүлэгч
- Хатгах хэсэгт идээт үрэвсэл, гэмтэлтэй байгаа эмчлүүлэгч
- Арьс судасны эмзэгшилтэй эмчлүүлэгч

Хэрэглэгдэх зүйлс

1. Ариун бээлий
2. Үзлэгийн бээлий
3. Натри хлоридын 0,9% уусмал (физиологийн уусмал)
4. Талбай халдваргүйжүүлэх уусмал – 5%-ийн тамедины уусмал
5. Спирт 70%
6. Ариун хөвөн бөмбөлөг
7. Ариун хямсаа
8. Тариур (3 мл, 5 мл)
9. Тохирох уян зүү - зориулалтын тагтай (24G, 22G, 20G, 18G, 16G,)
10. Чангалуур, ивүүр
11. Бэхлэгч наалт- Уян зүүний бэхлэгч ариун тунгалаг наалт, наалдуулагч гоюу наалт (пластер лент)
12. Уян зүүг хамгаалах ариун бинт
13. Гар халдваргүйжүүлэх уусмал
14. Хайч
15. Бөөр хэлбэрийн таваг
16. Аюулгүй хайрцаг, халдвартай хог хаягдал цуглуулах шар уут




Үйлдлийн өмнө: Хэрэглэгдэх зүйлсээ шалгаж бэлтгэнэ. Үүнд:

- Ажилбарт хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, тарилгын тэргэнцэрийн бэлэн байдлыг шалгана.
- Тарилга хийх орчинг бүрдүүлнэ.
- Эмчилгээний хуудас, сувилгааны түүхийг бэлдэнэ

Үйлдлийн явц



- Эмчлүүлэгчийн өрөөний хаалгыг нь тогшиж, зөвшөөрөл авч өрөөнд нь орно.
- Эмчлүүлэгчийнхээ нэрээр нь дуудаж мэндэлнэ.
- Эмчлүүлэгчид өөрийнхөө нэр, албан тушаал, хийх ажилбарын зорилгыг танилцуулна.
- Эмчлүүлэгчээс энэ ажилбарыг хийлгэж байсан эсэхийг лавлаад эмчлүүлэгчийг ажилбарт бэлтгэнэ. (Зураг 1).
- Зөв эмчлүүлэгчийг танихдаа овог нэр, төрсөн он сар өдрөөр нь дахин тулгаж хянана.
- Эмчийн бичсэн эмийг эмчилгээний хуудастай тулгана (Зураг 2).
- Эмийн бодисын бүрэн бүтэн байдал, ариун чанар ба хүчинтэй хугацааг шалгана.
- Зүү, тариурын бүрэн, бүтэн байдал, ариун ба хүчинтэй хугацааг шалгана.
- Гар халдваргүйжүүлэх уусмалаар гараа халдваргүйжүүлнэ. /Хэрэв илт бохирдсон тохиолдолд гарыг стандартын дагуу угаана/
- Нэг удаагийн бээлий өмсөнө.
- Тариурыг уутны “нээх” гэсэн хэсгээс эхлэн 2/3 хүртэл задлан тавина.
- Зүүгээ тариурт сайн бэхэлж., бүлүүрийг татаад буцаана (уян байдлыг хангаж байгаа).
- Тариурт 0,9% натри хлоридын (физиологийн) уусмалаас 2-3мл соруулж авна (Зураг 3).
- Нэг гарын дүрмээр зүүг таглана (Зураг 4).
- Тариурын хийг гаргаж зүүний үзүүр хүртэл тариаг дүүргэн (зүүний талстад үзэгдэх төдий (1-2 дусал)



тариурын уутанд буцаан хийнэ.

- Эмчлүүлэгчээ тохиромжтой байрлалд /хэвтээ эсвэл суугаа/ байрлуулна.
- Эмчлүүлэгчийн гарыг эвтэй байдалд байрлуулан гарын дор ивүүрийг тавьж, хатгах талбайг сонгоно (ихэвчлэн шулуун судас сонгоно).
- Судсанд хатгалт хийх талбайгаас дээш 2-4 см орчимд чангалуурыг байрлуулна (чангалахгүйгээр байрлуулахыг анхаарах).
- Ариун бээлийний бүрэн бүтэн байдлыг шалгаж зааврын дагуу задална.
- Уян зүү, ариун наалтыг ариун бээлийний дэлгэш дээр задална.
- Тарих талбайг төвөөс гадагшаа чиглэлтэй спирт, тамедин, спирт гэсэн дарааллын дагуу ариун хямсааг ашиглан ариутгана. Зураг 5. (ЭМЯ-ны шинэчлэгдсэн А/539 тоот тушаалын 5.3.6; 5.3.7 заалтуудыг харах)
- Үзлэгийн бээлийг тайлж, гарыг гар халдваргүйжүүлэх уусмалаар халдваргүйжүүлнэ.
- Ариун бээлийг өмсөнө.
- Чангалуурыг гүйцээн чангалж тавина (боломжтой бол туслах сувилагчийн тусламжтайгаар чангалуурыг чангалах).
- Уян зүүг гартаа барин эсрэг талын гарын эрхий хуруугаар арьсыг бага зэрэг татан 10-15 хэмийн өнцгөөр хатгана (Зураг 6).
- Энэ үед зүүний төгсгөлд цус орж ирмэгц хураагуур судсанд уян зүүг орсон гэж үзээд чангалуурыг суллана (Зураг 7).



- Уян зүүний хуванцар гуурсыг урагш түлхэж, чиглүүлэгч металл зүүг хойш аажим татан авна. Энэ үед судсанд байгаа уян зүүн дээр хуруугаар дарна. Цус гархаас сэргийлж уян зүүний онги хэсгийн дор ариун хөвөн бөмбөлөг байрлуулж болно (Зураг 8).
- Урьдчилан бэлдсэн 0,9% натри хлоридын (физиологийн) уусмалтай тариурыг холбон бүлүүрийн хойш татаж цус орж ирмэгц физиологийн уусмалыг аажим шахаж шалгаад тариурыг салгана (Зураг 9).
- Уян зүүг зориулалтын тагаар таглана. Хэрэв хөвөн бөмбөлөг тавьсан бол авна (Зураг 10).
- Уян зүүг бэхлэнэ. (Зураг 11, 12):
 - Зориулалтын тунгалаг наалтаар бэхэлж он, сар, өдөр, цагийг тодорхой бичиж тэмдэглэнэ.
 - Гоюу наалтыг нарийн цуулаад уян зүүний доогуур оруулан зөрүүлэн нааж, он, сар, өдөр, цагийг тодорхой бичиж тэмдэглэнэ.
- Уян зүүг хамгаалан ариун бинтээр боолт хийнэ (Зураг 13).



Үйлдлийн дараа

- Тарилгын хог хаягдлыг зааврын дагуу ангилан устгалд бэлтгэнэ.
- Бээлийг тайлна.
- Гараа угаана.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.
- Үйлчлүүлэгчээ эргэж хяналт тавина.



Анхаарах зүйл:

- Уян зүү тавих судас, байрлалыг зөв сонгох, аль болох хөдөлгөөн багатай гар хөлийн шулуун судсыг сонгож хийх
- Халдвар орохоос сэргийлж халдварын сэргийлэлт, хяналтын дэглэм чанд баримтлах
- 72 цагаас удаан хугацаагаар байлгахгүй байх, шаардлагатай бол өөр судсыг сонгож дахин тавих
- Эмчлүүлэгч халуурвал уян зүүг халдвар үүсгэгч эх үүсвэр байж болзошгүй гэж үзэн шалгах
- Уян зүү бөглөрөхөөс байнга сэргийлэх бөгөөд бөглөрсөн тохиолдолд зүүг шууд авах

Үйлдлийг гардан гүйцэтгэгч: Сувилагч, арга зүйч, бага эмч, их эмч

Үйлдлийн гүйцэтгэлд явцын болон эцсийн хяналт тавигч

Их эмч, бага эмч, арга зүйч, сувилагч

Уян зүү тавих талбай ба хэмжээс:

- Гарын сарвууны арын венийн судаснууд
- Гарын шууны венийн судаснууд
- Тохойн урд талын венийн судас
- Хөлийн тавхайн дээд хэсгийн венийн судас

Хэмжээ	Өнгө	Диаметр	Урсах шингэний хэмжээ мл/мин
24G	Шар	0,6	20 мл/мин
22G	Цэнхэр	0,8	25 мл/мин
20G	Ягаан	1	55 мл/ мин
18G	Ногоон	1,2	90 мл/мин
16G	Саарал	1,7	170 мл/ мин
14G	Улбар шар	2,0	265 мл/мин

ЯСАНД ШИНГЭН СЭЛБЭХ ХҮРЦ ХИЙХ АРГА ТЕХНИК

Зорилго: Яаралтай эмчилгээ, оношилгоо хийх

Заалт:

- Цус эргэлт зогссон эсвэл хүнд шоктой нярай болон хүүхдэд тарилга, цус, цусан бүтээгдэхүүн биед оруулах, шингэн сэлбэх эмчилгээ хийх, зарим шинжилгээг хийх зорилгоор венийн хатгалт хийхэд амаргүй (амжилтгүй) тохиолдолд төвийн венд хатгалт хийх, эсвэл мэс заслын аргаар венд хатгалт хийхээс илүүтэй ясанд шингэн сэлбэхийг зөвлөдөг.
- Яаралтай эмгэг (шок, сепсис, таталт, эпилепсийн статус, их хэмжээний түлэгдэлт, тархмал гэмтэлтэй өвчтөн)- үүдийн үед судсанд хатгалтыг хурдан хийх боломжгүй эсвэл эмнэлгийн нөхцөлд судсанд хатгалт хийх шаардлагатай ч олон удаа оролдоод амжилтгүй үед ясан дотор хатгалтыг хийнэ.



Эсрэг заалт


- Хатгалт хийх талбайд халдвар, түлэгдэл, хугаралтай
- Ижил талбайд өмнө нь хатгалт хийгдсэн
- Ижил ясанд өөр талбайд хатгалт хийгдсэн (оролдлого хийсэн)
- Ясны дутуу хөгжил, ясны сийрэгжилт, остеопени, осеопетросис

Хэрэглэгдэх зүйлс

1. Маск
2. Нүдний хамгаалалт
3. Ясны зүү (15 –18 голчтой байхгүй бол 21 хүртэл)
4. Физиологийн уусмал
5. Тариур 5мл 2 ширхэг
6. Ивүүр
7. Ариутгасан хөвөн бөмбөлөг
8. Ариун бээлий
9. Наалдуулагч лент
10. Ариутгагч уусмал /повидон иод/
11. Мэдээгүйжүүлэх уусмал /лидокайн 1%/
12. Бөөр хэлбэрийн таваг
13. Аюулгүй хайрцаг, халдвартай хог хаягдлын шар уут



Үйлдлийн явц



Хатгах талбайн дүрслэл

- Хүүхдийн хөлийг өвдгөөр 30° өнцгөөр нугалж түнхний үеэр бага зэрэг гадагш эргүүлсэн байдалд хөлийг байрлуулж, өвдөг доор нь ивүүр хийнэ. Өсгий ширээн дээр хүрч байвал зохино (Зураг 1).



- Шаантны төвгөр рүү бага зэрэг дотогш (1 см хүртэл) ба шаантны хавтгай гадаргуугаас ойролцоогоор 1-2 см доор цэгийг тодорхойлж, өсөлтийн зоноос зайтай хатгах талбайг сонгоно (Зураг 2)



Хатгалт хийж буй байдал



Ясны чөмөгнөөс соруулах



Дуслын систем залгасан байдал

- Гараа угааж ариун бээлий өмсөнө.
- Хатгалт хийх цэг, орчмыг антисептик уусмалаар ариутгана. (жишээ нь: повидон иодын уусмал)
- Хэрвээ хүүхэд сэрүүн бол арьсыг нэвчүүлэн, арьсан доорх эд, мөн ясны бүрхүүл хальсыг 1%-ийн лидокайны уусмалаар мэдээгүйжүүлнэ.
- Хөлийн хатгалт хийх талбайгаас дистал-гадна хэсэгт хатгалт хийхгүй гараараа хуруу-алгаа оролцуулан хатгалт хийх хүчний эсрэг хөлийг атган барих, мөн энэ ажилбарын үед хөлний дистал хэсэг хөдлөхөөс сэргийлнэ. (Зураг 3)
- Ариутгасан бээлийтэй баруун гараараа сонгосон газраа дахин тэмтэрч үзнэ.
- Ясны зүүг 90° өнцгөөр аажим эргүүлэх хөдөлгөөнөөр хатган, ясны холтослог давхаргыг нэвтэрч, ясны чөмгөнд хүрэх үед зүүний хөдөлгөөн саад эсэргүүцэлгүй болно. Үүнийг эмч мэдрэх нь чухал юм. Зүү ясанд хөдөлгөөнгүй зоогдсон байх ёстой.
- Сэтгүүрийг сугалж аваад 5 мл тариураар чөмөгнөөс 1 мл-ийг соруулж авна. (Зураг 4)
- 2 дахь 5 мл зүүгээр физиологийн уусмал 3 мл-ийг шахаж арьсан доор шингэн гарч байгаа эсэхийг ажиглана.
- Бүх төрлийн кристаллойд шингэн, цус, цусан бүтээгдэхүүн, эмийн бодис хийж болно. (Зураг 5)
- Ясны чөмөгнөөс цусны глюкоз, цусны бүлэг, гемоглобин, цусны хийн шинжилгээ, нян судлалын шинжилгээ хийж болно.
- Шингэнийг судсаар хийх боломжтой болмогц ясанд шингэн сэлбэхийг зогсооно. Ясан дотор шингэн сэлбэх

эмчилгээ 8 цагаас удаан үргэлжлэх ёсгүй.

- Зүүг авахдаа зүүний ишнээс атгаж татахын хамт бага зэрэг эргүүлэх хөдөлгөөн хийж авна. Хатгалт хийсэн талбайд асептик арга аргачлалын дагуу боолт хийнэ.

Хүндрэл

- Ясны холтослог давхаргыг бүрэн нэвтрээгүй байх /арьсан доор нэвчдэс үүсэх/
- Ясны арын холтослог давхарт нэвт хатгах
- Өсөлтийн бүсийг гэмтээх
- Халдвар
- Цус алдалт
- Ясны үрэвсэл
- Өөхөн эмболизм
- Хугарал
- Эпифизийн гэмтэл

Үйлдлийг гардан гүйцэтгэгч: Эмч

Үйлдлийн гүйцэтгэлд явцын болон төгсгөлийн хяналт тавигч:

Үйлдэл гүйцэтгэсэн эмч

СУДСАНД ТАРИЛГА ХИЙХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=1xHPoSVJLV4>

Түлхүүр үг: Судсанд тарилга хийх арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Эмчилгээ, оношилгооны

Тодорхойлолт: Эмчийн заалтаар тарилгыг эмчлүүлэгчийн судсанд тарина.

Заалт:

Эмчийн заалтаар судсанд тарьж болох эмүүдийг тарина

Тарилгын талбай:


- Тохойны
- Шагайны
- Сарвууны
- Эрхий хурууны арын
- Чамархайн хураагуур (хүүхдэд) судсуудыг голчлон сонгоно.



Эсрэг заалт: Судсанд тарьж хэрэглэдэггүй эмүүдийн заалттай ижил байна.

Хэрэглэгдэх зүйлс

1. Тарих эм
2. Тохирох зүү тариур
3. Эмийн бодисыг шингэлэх болон найруулах физиологийн уусмал
4. Чангалуур, ивүүр
5. Ариутгасан хөвөн бөмбөлөг
6. Бээлий
7. Туншил хөрөөдөгч (шаардлагатай тохиолдолд)
8. Наалдуулагч лент (пластер лент)
9. Ариутгагч уусмал буюу спирт 70%
10. Гар халдваргүйжүүлэх уусмал
11. Бөөр хэлбэрийн таваг
12. Аюулгүй хайрцаг, халдвартай хог хаягдлын сав



Үйлдлийн өмнө: Хэрэглэгдэх зүйлсээ шалгаж бэлтгэнэ. Үүнд:

- Ажилбарт хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, тарилгын тэргэнцэрийн бэлэн байдлыг шалгана.
- Тарилга хийх орчинг бүрдүүлнэ.
- Эмчилгээний хуудас, сувилгааны түүхийг бэлдэнэ.

ҮЙЛДЛИЙН ЯВЦ



1



2




3



4

- Эмчлүүлэгчийн өрөөний хаалгыг нь тогшиж, зөвшөөрөл авч өрөөнд нь орно.
- Эмчлүүлэгчийнхээ нэрээр нь дуудаж мэндлээд, эмчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгнө.
- Эмчлүүлэгчид өөрийнхөө нэр, албан тушаалыг танилцуулна.
- Хийх ажилбарын зорилгыг танилцуулна (Зураг 1).
- Эмчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Зөв эмчлүүлэгчийг танихдаа овог нэр, төрсөн он сар өдрөөр нь дахин тулгаж хянана (Зураг 2).
- Эмчийн бичсэн эмийг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Эмийн бодисын бүрэн бүтэн байдал, ариун чанар ба хүчинтэй хугацааг шалгана
- Зүү, тариурын бүрэн бүтэн байдал, ариун ба хүчинтэй хугацааг шалгана.
- Гар халдваргүйжүүлэх уусмалаар гараа халдваргүйжүүлнэ. /Хэрэв илт бохирдсон тохиолдолд гарыг стандартын дагуу угаана/
- Нэг удаагийн бээлий өмсөнө, шаардлагатай тохиолдолд ариун бээлий өмсөнө.
- Тариурыг уутнаас гаргахын тулд “нээх” гэсэн хэсгээс эхлэн 2/3 хүртэл задлан, тавина.
- Зүүгээ тариурт сайн бэхэлж өгнө (зүүний талстат-налуу хэсгийг тариурын хуваарьтай хэсэгт тааруулж, тариурт бэхэлж, бүлүүрийг татаад буцаах).
- Тариурт эмийн бодисыг соруулж авна (Зураг 3).
- Нэг гарын дүрмээр зүүг хамгаална



(Зураг 4).

- Тариурын хийг гаргаж, уусмал зүүний талстад үзэгдэх төдий (1-2 дусал) гаргаад тариурын уутанд буцаан хийнэ.
- Эмчлүүлэгчийг зөв байрлуулж (суугаа, хэвтээ, эсвэл түрүүлгээ харсан байрлал) тарих тайлбайгаа зөв сонгоно (ихэвчлэн шулуун судас сонгоно).
- Мөчнүүдийн хураагуур судсанд тарилга хийх тохиолдолд сонгосон судаснаасаа 2-4 см орчим дээр чангалуурыг зөвхөн хураагуур судасны урсгалыг хааж, тараагуур судасны лугшилт мэдэгдэж байхаар бэхэлнэ.
- Хатгах хэсгийг спирттэй бөмбөлгөөр цусны урсгалын дагуу ариутгана (Зураг 5).
- Зүү тариураа арьстай 10-15 хэмийн налуугаар судсаа чиглүүлэн, эхлээд арьсыг, дараа нь судсыг хатгана (Зураг 6).
- Зүү судсанд орсон гэж үзсэн тохиолдолд бүлүүрээ хойш нь татаж шалгана (Зураг 7).
- Чангалуурыг аажим суллана. Хэрэв цус шинжилгээнд авч буй бол цусаа авч дууссаны дараа чангалуурыг суллана (Зураг 8).
- Зүү судсанд байгаа эсэхийг дахин шалгана.
- Эмийн бодисыг маш аажим шахна. Ялангуяа амьсгал, зүрх судасны үйл ажиллагааг дэмжих эмүүд, хлорт кальци, зуфиллин зэрэг эмүүдийг эмчийн заалтаар маш болгоомжтой аажим шахна (Зураг 9).



- Зүү тариурыг сугалан авч, арьсыг цоолсон хэсэгт ариутгасан хөвөн бөмбөлөг тавьж, наалдуулагч бүхий лентээр тогтооно (Зураг 10, 11).
- Тариурын зүүг тариураас салгахгүйгээр, дахин таглахгүйгээр аюулгүй хайрцагт хийнэ.
- Хэрэв зүүг зайлшгүй таглах бол аюулгүй таглах “нэг гарын” дүрмийг баримтлан гар хүргэхгүйгээр таглана.

Үйлдлийн дараа

- Тариурын хог хаягдлыг зааврын дагуу ангилан устгалд бэлтгэнэ.
- Бээлийг тайлна.
- Гараа угаана.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.
- Үйлчлүүлэгчээ хянана.



Анхаарах зүйлс

- Чангалуурыг зөв тавих
- Зүүг зөв сонгох
- Тав + Таван зөвийн дүрэм баримтална.
- Бэлтгэх бүх үйл явцад хэрэглэгдэх материалуудыг ариун газар хадгалах ёстой.
- Зүүг хамгаалалтын уутнаас гаргасны дараа маш болгоомжтой харьцна.
- Халдварлагдсан хог хаягдлыг журмын дагуу ангилагдсан эсэхийг



шалгана.

- Судас хагарч, хөхрөх,
- Тариурт хий орж, хийн бөглөрөл үүсэх,
- Эмчлүүлэгчийн нэрийг нарийвчлан нягталж тулгаагүйгээс буруу эмчлүүлэгчийг сонгох, буруу эмийн бодис тарих зэрэг хүндрэлээс сэргийлэх нь зүйтэй.

Эмийн бодис судсаар нэвчсэн үед авах арга хэмжээ:

- Эмийн бодисыг яаралтай зогсооно.
- Эмийн бодисын нэвчсэн хэсэгт хүйтэн жин тавих
- Эмчид мэдээлнэ.
- Эмийн бодис нэвчсэн хэсгийн байдлыг тасралтгүй ажиглаж шаардлагатай эмчилгээг хийнэ.
- Дахин тариа хийх тохиолдолд өөр газар сонгон хийнэ.

Үйлдлийн гүйцэтгэлд явцын болон эцсийн хяналт тавигч

Сувилагч, ахлах сувилагч, бага эмч, их эмч

БУЛЧИНД ТАРИЛГА ХИЙХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=3pE2yyx5hdc>

Түлхүүр үг: Булчинд тарилга хийх арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Эмчилгээний зорилгоор үйлчлүүлэгчид тарилгыг хийнэ.

Тодорхойлолт: Эмчийн заалтаар тарилгыг эмчлүүлэгчийн булчинд тарих

Заалт: Эмчийн заалтаар эмийг булчинд тарьж хийх

Тарилгын талбай:

- Мөрний булчин
- Өгзөгний гадна дээд хэсэг
- Өгзөгний урд дээд хэсэг
- Гуяны гадна дунд хэсэг
- Гуяны урд дунд хэсэг



Эсрэг заалт: Булчинд тарьж хэрэглэдэггүй эмүүдийн заалттай ижил байна.

Үйлдлийн өмнө: Хэрэглэгдэх зүйлсээ шалгаж бэлтгэнэ. Үүнд:

- Ажилбарт хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, тарилгын тэргэнцэрийн бэлэн байдлыг шалгана.
- Тарилга хийх орчинг бүрдүүлнэ.
- Эмчилгээний хуудас, сувилгааны түүхийг бэлдэнэ.

Хэрэглэгдэх зүйлс:

1. Тарих эм
2. Тохирох зүү тариур (3 мл, 5 мл)
3. Нөөц зүү (20-23G x 1" - 3")
4. Ариутгасан хөвөн бөмбөлөг
5. Ариун хямсаа
6. Үзлэгийн бээлий
7. Туншил хөрөөдөгч (шаардлагатай тохиолдолд)
8. Наалдуулагч лент (пластер лент)
9. Ариутгагч уусмал буюу спирт 70%
10. Гар халдваргүйжүүлэх уусмал
11. Аюулгүй хайрцаг, халдвартай хог хаягдал цуглуулах шар уут



ҮЙЛДЛИЙН ЯВЦ



- Эмчлүүлэгчийн өрөөний хаалгыг нь тогшиж, зөвшөөрөл авч өрөөнд нь орно.
- Эмчлүүлэгчийнхээ нэрээр нь дуудаж мэндлээд эмчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ өгнө.
- Эмчлүүлэгчид өөрийнхөө нэр, албан тушаал, хийх ажилбарын зорилгыг танилцуулна.
- Эмчлүүлэгчээс энэ ажилбарыг



хийлгэж байсан эсэхийг лавлаад ажилбарт бэлтгэнэ.

- Зөв эмчлүүлэгч эсэхийг танихдаа овог нэр, төрсөн он сар өдрөөр нь дахин тулгаж хянана (Зураг 1).

- Эмчийн бичсэн эмийг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.

- Эмийн бодисын бүрэн бүтэн байдал, ариун чанар ба хүчинтэй хугацааг шалгана.

- Зүү, тариурын бүрэн бүтэн байдал, ариун ба хүчинтэй хугацааг шалгана (Зураг 2).



- Гар халдваргүйжүүлэх уусмалаар гараа халдваргүйжүүлнэ. /Хэрэв илт бохирдсон тохиолдолд гарыг стандартын дагуу угаана/

- Нэг удаагийн бээлий өмсөнө (шаардлагатай тохиолдолд) (Зураг 3).



- Тариурын уутны “нээх” гэсэн хэсгээс эхлэн 2/3 хүртэл задлан, тавина.

- Зүүгээ тариурт зүүний талстатналуу хэсгийг тариурын хуваарьтай хэсэгт тааруулж сайн бэхэлж өгнө.

- Тариурт эмийн бодисыг соруулж авна (Зураг 4).

- Нэг гарын дүрмээр зүүг таглана (Зураг 5).



- Тариурын хийг гаргаж зүүний үзүүр хүртэл (зүүний талстатналууд төдий 1-2 дусал) эмийн бодисыг гаргаад, тариурын уутанд буцаан хийнэ (Зураг 6).

- Эмчлүүлэгчийг зөв байрлуулж (суугаа, хэвтээ, эсвэл түрүүлгээ харсан байрлалд), тарих тайлбайгаа



зөв сонгоно.

- Хатгах хэсгийг спирттэй бөмбөлгөөр дотроос гадагш чиглэлтэй ариутгана (Зураг 7)
- Нэг гараар арьсыг тэнийлгэж, нөгөө гараар зүү тариурыг 90 хэмийн өнцгөөр булчингийн нэхмэл эдэд зүүний 2/3-ыг далд ортол хатгана (Зураг 8).




- Бүлүүрийг хойш татаж, судас дайрсан эсэхийг шалгана (Зураг 9).
- Гараа салгалгүйгээр бүлүүрийг аажим шахаж, эмийн бодисыг тарих хэсгийн булчинд аажим шахаж оруулна (Зураг 10).



Үйлдлийн дараа:



- Зүү тариурыг сугалан авч, арьсыг цоолсон хэсэгт ариутгасан хөвөн бөмбөлөг тавьж, наалдуулагч бүхий лентээр тогтооно. (Зураг 11).
- Тариурын зүүг тариураас салгахгүйгээр, дахин таглахгүйгээр аюулгүй хайрцагт хийнэ (Зураг 12).
- Хэрэв зүүг зайлшгүй таглах бол аюулгүй таглах “нэг гарын” дүрмийг баримтлан гар хүргэхгүйгээр таглана.



Үйлдлийн дараа

- Тарилгын хог хаягдлыг зааврын дагуу ангилан устгалд бэлтгэнэ.
- Бээлийг тайлна.
- Гараа угаана.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ
- Үйлчлүүлэгчээ хянана.



Анхаарах зүйл

- Нярай болон хөлд ороогүй хүүхдэд өгзөгний гадна дээд хэсэгт тарилга хийж болохгүй.
- Зүүг зөв сонгох
- Тав + таван зөвийн дүрэм баримтлах
- Зүү хатгасны дараа судас дайрсан эсэхийг заавал шалгах
- Судас дайрсан тохиолдолд өөр газар, өөр зүү тариураар хатгах
- Бэлтгэх бүх үйл явцад хэрэглэгдэх материалуудыг ариун газар хадгалах
- Зүүг хамгаалалтын уутнаас гаргасны дараа маш болгоомжтой харьцах
- Халдварлагдсан хог хаягдлыг журмын дагуу ангилагдсан эсэхийг шалгах.
- Судас хагарч, хөхрөх эрсдлээс сэргийлэх



- Тариурт хий орж, хийн бөглөрөл үүсэхээс сэргийлэх
- Эмчлүүлэгчийн нэрийг нарийвчлан нягталж тулгаагүйгээс буруу эмчлүүлэгчийг сонгох, буруу эмийн бодис тарих зэрэг хүндрэлээс сэргийлэх

Үйлдлийн гүйцэтгэлд явцын болон эцсийн хяналт тавигч:

Сувилагч, ахлах сувилагч, бага эмч, их эмч

АРЬСАН ДОР ТАРИЛГА ХИЙХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=Zzud6UpoAMQ>

Түлхүүр үг: Арьсан дор тарилга хийх арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Оношилгоо, эмчилгээний


Тодорхойлолт: Эмчийн заалтаар тарилгыг эмчлүүлэгчийн арьсан дор тарих

Заалт: Арьсан дор тарьж хэрэглэдэг эмүүдийг заалтын дагуу хийнэ. Үүнд:

- Витаминууд
- Вакцин
- Инсулин
- Мэдээ алдуулах, өвчин намдаах, наркотик эм
- Бусад /заалт бүхий тарилга/

Тарилгын талбай:

- Бугалганы гадна
- Далны доод хэсэг
- Хэвлий, хүйсний орчим
- Өгзөгний дээд хэсэг
- Гуяны урд, гадна хажуу хэсэг





Эсрэг заалт: Арьсан дор тарьж болохгүй заалт бүхий тарилга

Үйлдлийн өмнө: Хэрэглэгдэх зүйлсээ шалгаж бэлтгэнэ. Үүнд:

- Ажилбарт хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэж, тарилгын тэргэнцэрийн бэлэн байдлыг шалгана.
- Тарилга хийх орчинг бүрдүүлнэ.
- Эмчилгээний хуудас, сувилгааны түүхийг бэлдэнэ.

Хэрэглэгдэх зүйлс



1. Тарих эм
2. Тохирох зүү тариур (1мл,3 мл)
3. Зүү 23G - 25G (нөөц)
4. Ариутгагч уусмал буюу спирт 70%
5. Ариун хөвөн бөмбөлөг
6. Ариун хямсаа
7. Үзлэгийн бээлий
8. Туншил хөрөөдөгч (шаардлагатай тохиолдолд)
9. Наалдуулагч лент (пластер лент)
10. Гар халдваргүйжүүлэх уусмал
11. Аюулгүй хайрцаг, халдвартай хог хаягдал цуглуулах шар уут

ҮЙЛДЛИЙН ЯВЦ



- Эмчлүүлэгчийн өрөөний хаалгыг нь тогшиж, зөвшөөрөл авч өрөөнд нь орно.
- Эмчлүүлэгчийнхээ нэрээр нь дуудаж мэндлээд биеийн байдалд үнэлгээ өгнө.
- Эмчлүүлэгчид өөрийнхөө нэр, албан тушаал, хийх ажилбарын зорилгыг танилцуулна.
- Эмчлүүлэгчээс энэ ажилбарыг хийлгэж байсан эсэхийг лавлаад, эмчлүүлэгчийг энэ ажилбарт бэлтгэнэ (Зураг 1).



- Зөв эмчлүүлэгч эсэхийг танихдаа овог нэр, төрсөн он сар өдрөөр нь дахин тулгана (Зураг 2).



- Эмчийн бичсэн эмийг эмчилгээний хуудастай тулгаж шалгана.
- Эмийн бодис, зүү, тариурын бүрэн бүтэн байдал, ариун чанар ба хүчинтэй хугацааг шалгана (Зураг 3).



- Гар халдваргүйжүүлэх уусмалаар гараа халдваргүйжүүлнэ. /Хэрэв илт бохирдсон тохиолдолд гарыг стандартын дагуу угаана/ (Зураг 4).
- Нэг удаагийн бээлий өмсөнө (шаардлагатай тохиолдолд).



- Тариурын уутны “нээх” гэсэн хэсгээс эхлэн эхлэн 2/3 хүртэл задлана тавьна.
- Зүүгээ тариурт сайн бэхэлж өгнө (зүүний талстат-налуу хэсгийг тариурын хуваарьтай хэсэгт тааруулж, бүлүүрийг татаад буцаан, уян байдлыг хангах байдлаар).
- Тариурт эмийн бодисыг соруулж авна (Зураг 5).



- Нэг гарын дүрмээр зүүг таглана (Зураг 6).



- Тариурын хийг гаргаж зүүний үзүүр хүртэл (зүүний талстад үзэгдэх төдий 1-2 дусал) эмийн бодисыг гаргаад, тариурын уутанд буцаан хийнэ.
- Эмчлүүлэгчийг зөв (суугаа, хэвтээ эсвэл түрүүлгээ харсан байрлалд) байрлуулж, тарих тайлбайгаа зөв сонгоно.
- Хатгах хэсгийг спирттэй бөмбөлгөөр дотроос гадагш чиглэлтэй ариутгана (Зураг 7)



- Нэг гараараа арьсыг чимхэн барьж, нөгөө гараараа зүү тариураа арьстай 45-60 хэмийн өнцгөөр арьсны өөхөн эдэд 2/3-ыг далд ортол хатгана (Зураг 8).



- Бүлүүрийг хойш татаж, судас таарсан эсэхийг шалгана. Хэрэв судас таарсан бол өөр зүү тариураар, өөр газар тариаг дахин хийнэ.
- Эмийн бодисыг аажим шахна (Зураг 9).



- Зүү тариурыг сугалан авч, арьсыг цоолсон хэсэгт ариутгасан хөвөн бөмбөлөг тавьж, наалдуулагч бүхий лентээр тогтооно (Зураг 10).



- Тариурын зүүг тариураас салгахгүйгээр, дахин таглахгүйгээр аюулгүй хайрцагт хийнэ (Зураг 11).
- Хэрэв зүүг зайлшгүй таглах бол аюулгүй таглах “нэг гарын” дүрмийг баримтлан гар хүргэхгүйгээр таглана.

Үйлдлийн дараа

- Тарилгын хог хаягдлыг зааврын дагуу ангилан устгалд бэлтгэнэ.
- Бээлийгээ тайлна.
- Гараа угаана.
- Хийсэн ажилбараа бичиж тэмдэглэнэ.
- Үйлчлүүлэгчээ эргэж хянана.

**Анхаарах зүйлс**

- Зүү хатгасны дараа судас дайрсан үгүйг заавал шалгана. Судас дайрсан тохиолдолд өөр газар, өөр зүү тариураар хатгах
- Бэлтгэх бүх үйл явцад хэрэглэгдэх материалуудыг ариун газар хадгалах ёстой
- Зүүг хамгаалалтын уутнаас гаргасны дараа маш болгоомжтой харьцах
- Халдварлагдсан хог хаягдлыг журмын дагуу ангилагдсан эсэхийг шалгах
- Судас хагарч, хөхрөх эрсдлээс сэргийлэх
- Эмчлүүлэгчийн нэрийг нарийвчлан нягталж тулгаагүйгээс буруу эмчлүүлэгчийг сонгох, буруу эмийн бодис тарих зэрэг хүндрэлээс сэргийлэх нь зүйтэй.

Үйлдлийн гүйцэтгэлд явцын болон эцсийн хяналт тавигч: Сувилагч, ахлах сувилагч, бага эмч, их эмч

ОЁДОЛ ТАВИХ, ЦУС ТОГТООХ, ШАРХ ЦЭГЦЛЭХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=p5xgRqOdZrg>

Түлхүүр үг: Шарханд анхдагч цэгцлэлт хийх

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Янз бүрийн шалтгааны улмаас хүний биеийн гадна бүрхүүл болох арьс салст бүрхэвч анатомийн бүрэн бүтэн байдлаа алдаж гэмтэхийг зөөлөн эдийн ил гэмтэл буюу шарх гэнэ.

Шарханд анхдагч цэгцлэлт хийх зорилго


- Цус тогтоох
- Хоёрдогч халдвараас сэргийлэх
- Шархны эдгэрэлтэнд таатай нөхцөл бүрдүүлж өгөх

4 гол зарчмыг баримтлах ёстой:

- Үхэжсэн эдийг цэвэрлэж, шархыг угаах
- Шарханд чийглэг орчинг бүрдүүлж өгөх
- Шарханд нэмэлт гэмтэл үүсэхээс сэргийлэх
- Шархны эдгэрэлтэнд шаардлагатай материалуудаар хангаж өгөх


Үйлдлийн өмнө: Эмч, сувилагч хэрэглэгдэх зүйлсээ шалгаж бэлдэнэ.

ШАРХАНД ОЁДОЛ ТАВИХ




1. Шарханд хэсгийн мэдээ алдуулалт хийнэ.

Хэсгийн мэдээ алдуулалтыг хийхдээ шархны ирмэгээс тариурыг арьсан доорх зөөлөн эд рүү хатгаж, бүлүүрийг хойш татан судас дайрсан эсэхийг шалгаж, нэвчүүлэх маягаар хийнэ. Хэсгийн мэдээ алдуулалтыг Новокаины 0.5 болон 1% эсвэл Лидокаины 2%-ийн уусмалаар хийнэ (Зураг 1).



2. Шархыг угаана.

Шарх руу физиологийн уусмалаар даралттай шахаж, шүрших маягаар тасралтгүй сайтар угаана (Зураг 2).



3. Шархны гадны биет болон үсийг гаргаж авна.

Шархны хөндийд байх нүдэнд харагдах гадны биет болон үсийг анатомийн хямсаагаар барьж болгоомжтой татаж гаргаж авна.




4. Шархны амьдрах чадваргүй болсон эдийг авах

Шархны амьдрах чадваргүй болсон эдийг мэс заслын хямсаагаар барьж, зөөлөн татаж доогуур нь хайчаар болон хутгаар болгоомжтой зүсэж авна.


5. Шархны ирмэгийг өөлөх

Шархны ирмэгийг хутга эсвэл хайчаар зүсэж тэгшилж зууван хэлбэрээр өөлж авна (Зураг 3,4).



6. Шархны талбай болон шархны хөндийг үжил эсэргүүцлийн уусмалаар цэвэрлэх

Шархны талбайг повидон иод, тамедин, перкись г.м үжил эсэргүүцлийн уусмалаар төвөөс зах руу чиглэлтэй арчиж цэвэрлэнэ. Шархны хөндийг мөн адил арчиж цэвэрлэж, хуурай бөмбөлгөөр хуурайшуулна (Зураг 5).




7. Том судаснаас цус гарч байвал боож цус тогтооно.

Том судаснаас цус гарч байвал тухайн судсыг багажаар барьж доогуур нь хатган боож, цус тогтооно (Зураг 6).





8. Арьсан доорх өөхөн эдэд оёдол тавих

А. Зүүг арьсан доорх өөхөн эдийн хананаас доороос дээш чиглэлтэй хатгаж гаргаж ирнэ (Зураг 7).





Б. Зүүг нөгөө хананы дээрээс доош чиглэлтэй хатгаж гаргаж ирнэ (Зураг 8).







В. Утсыг 3 удаа сайтар зангидаж бага зэргийн сахал үлдээж хайчилна (Зураг 9,10).






9. Арьсанд оёдол тавих /simple/

А. Шархны ирмэгийг мэс заслын хямсаагаар барьж зөөлөн татаж байгаад 90 хэмээр зүүг хатган оруулж, нөгөө ирмэгийг хямсаагаар барьж зөөлөн татаж, нэг удаагийн үйлдлээр нөгөө талаас нь гаргаж ирнэ (Зураг 11).





Б. Шархны зах ирмэгүүдийг нийлүүлэн аль нэг талд 3 дахин зангидаж 0.5 см-ийн сахал үлдээж хайчилна (Зураг 12).






10. Арьсанд оёдол тавих /Mattress/


А. Энгийн оёдол тавьж байгаатай адил зүүг арьсанд хатгаж гаргаж ирнэ (Зураг 13).



Б. Эргүүлэн шархны арьсны хоёр ирмэгийг хатгана (Зураг 14).



В. Шархны зах ирмэгүүдийг нийлүүлэн 3 дахин зангидаж 0.5 см-ийн сахал үлдээж хайчилна (Зураг 15).



11. Шархны талбайг үжил эсэргүүцлийн уусмал цэвэрлэнэ.

Шархны талбайг повидон иод, тамедин, перкись г.м үжил эсэргүүцлийн уусмал шингээсэн марль бөмбөлгөөр төвөөс зах руу чиглэлтэй арчиж цэвэрлэнэ (Зураг 16).



12. Ариун боолт хийнэ.

Шархны эдгэрэлтэнд шаардлагатай материалуудаар хангаж өгөх ба шархыг бинтээр боох болон наалдуулагч наалтаар нааж тогтооно (Зураг 17).

Үйлдлийн дараа: Зөвлөгөө өгнө:

- Амбулаторийн хяналтанд байх
- Ариун боолт хийлгэх
- Хүйтэн жин тавих
- Шаардлагатай тохиолдолд өргөн хүрээний антибиотик зөвлөх
- Өвдөлт намдаах эм зөвлөх

ЦУС ТОГТООХ ЧАНГАЛУУР ТАВИХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=qyRImBBPQzw>

Түлхүүр үг: Цус тогтоох Чангалуур тавих

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго

- Цус тогтоох
- Хүндрэлээс сэргийлэх

Хэрэглэгдэх зүйлс:

- Чангалуур
- Хөвөн эсвэл зөөлөн давуу



Үйлдлийн өмнө: Эмч, сувилагч хэрэглэгдэх зүйлсээ шалгаж бэлтгэнэ.

Үйлдлийн явц:

- Эмчлүүлэгчтэй мэндэлнэ.
- Өөрийнхөө нэр, албан тушаалыг танилцуулна.
- Хийх ажилбарын зорилгыг танилцуулна.
- Эмчлүүлэгчээс гэмтлийн асуумж авна.
- Эмчлүүлэгчийг тохиромжтой зөв байрлалд /суугаа эсвэл хэвтээ/ байрлуулна.

ЭНГИЙН ЦУС ТОГТООХ АРГА



1. Шархан дээр сайтар дарж өгнө.
2. Дарж байгаад нугалсан самбай давхарлаж тавин, даралтат боолт хийнэ. (Зураг 1).

**ХЭРЭВ ЦУС АЛДАЛТ
ТОГТОХГҮЙ БАЙВАЛ
ЧАНГАЛУУР ТАВЬЖ
ЦУС АЛДАЛТЫГ ЗОГСООНО.**

ЧАНГАЛУУР ТАВИХ ТЕХНИК



1. Артерийн судсыг нь чангаар хуруугаараа цус алдалт зогсох хүртэл дарах буюу эсвэл яс руу зангидсан гараараа дарж өгнө.

Цус дахин алдуулахгүйн тулд чангалуур тавих хүртэл дарсан гол судсаа тавьж болохгүй. Хэрэв ядарч эхэлвэл хажууд байгаа хүмүүсээс өөрийн хуруун дээр дарж туслахыг гуйна (Зураг 2).



2. Чангалуурыг зөөлөн дотортой материалаар давхарлаж тавих бөгөөд шархнаас дээш хэсэгт шархандаа аль болох ойрхон тавина (Зураг 3).



3. Чангалуурыг мөч доогуур оруулж сайтар татна.

Чангалуурыг эхлээд эргүүлж шархнаас цус алдалт зогссон эсэхийг шалгана (Зураг 4).



4. Чангалуурын дараагийн эргэцийг арай сулавтар гарч ирсэн эргүүлгээр, өмнөх эргэцийн талыг оролцуулан боож өгнө (Зураг 5).



5. Чангалуурын доор боолт хийсэн он, сар, өдөр болон цагийг бичсэн бичгийг хийж үлдээнэ (Зураг 6).

ЧАНГАЛУУР БАЙХГҮЙ БОЛ МУШГИА ЧАНГАЛУУР АШИГЛАНА.



1. Ойр зуурын материалаас (даавуу, толгойн боолт) хийсэн мушгиа чангалуурыг шархны дээгүүр, мөчийг тойруулан, хувцасны дээгүүр эсвэл даавууг арьсан дээр тавьж түүний захуудыг гогцоо болгон зангидна (Зураг 7).



2. Зангидсан гогцоондоо мод (эсвэл өөр ижил зүйл) зангидалтын доогуур хийнэ (Зураг 8).



3. Модоо эргүүлэнгээ мушгиа чангалуураа цус алдалт зогсох хүртэл чангална. Модоо сулрахаас сэргийлж сайн чангална. Мушгиа чангалуурыг чангалуурын дүрмийн дагуу тавина (Зураг 9).



Анхаарах зүйлс

- Мөчдийн хувьд артерийн судсыг цус алдаж байгаа газраас дээгүүр, хүзүүн дээр бол шархны доогуур эсвэл шархны дээр дарна.
- Чангалуурыг 2 ястай хэсэгт хийхгүй.
- Чангалуур тавих дээд хугацаа 30 минут байна.

Үйлдлийн дараа

- Эмчлүүлэгчийг эмнэлэг рүү зөөвөрлөнө.

ШИНЖИЛГЭЭНД ЦУС АВАХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=OT7Pz8tel7c>

Түлхүүр үг: Шинжилгээнд цус авах арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Оношилгоо, эмчилгээний


Тодорхойлолт: Эмчийн заалтаар үйлчлүүлэгчийн хураагуур судсыг хатгаж, шинжилгээнд цус авч, сувилахуйн тусламж үзүүлэх

Заалт: Эмчийн заалтаар дараах тохиолдолд

- Цусан дахь цөсний будагч бодисын хэмжээг тодорхойлох
- Цусны ерөнхий болон дэлгэрэнгүй, биохимийн шинжилгээ хийх
- Цусны ариун чанарыг үзэх зорилгоор хураагуур судсыг хатгаж цус авна.

Цус авах талбай:


- Тохойны
- Шагайны
- Сарвууны
- Эрхий хурууны арын
- Чамархайн хураагуур (хүүхдэд) судсуудыг голчлон сонгоно.



Эсрэг заалт: БайхгүйХэрэглэгдэх зүйлс

Хэрэглэгдэх зүйлс

1. Ариун зүү (18 - 20G)
2. Бөөр хэлбэрийн таваг
3. Чангалуур
4. Ивүүр
5. Ариутгагч уусмал
6. Хөвөн бөмбөлөг
7. Наалдуулагч лент
8. Ариун хуруу шил (вакутейнер)
9. Шинжилгээний бичиг (тухайн хүний)
10. Бээлий
11. Аюулгүй хайрцаг



Үйлдлийн өмнө

- Сувилагч үйлдэлд хэрэглэгдэх зүйлсээ бэлтгэнэ.



- Үйлчлүүлэгчийн өрөөний хаалгыг нь тогшиж, зөвшөөрөл авч өрөөнд нь орно.
- Үйлчлүүлэгчийнхээ нэрээр нь дуудаж мэндэлнэ.
- Үйлчлүүлэгчид өөрийнхөө нэр, албан тушаалыг танилцуулна.
- Хийх ажилбарын зорилгыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна (Зураг 1).




- Үйлчлүүлэгчийг танихдаа овог нэр, төрсөн он сар өдрөөр нь дахин тулгаж хянана.
- Эмчийн бичсэн шинжилгээг тулгана.
- Зүүний бүрэн бүтэн байдал, ариун ба хүчинтэй хугацааг шалгана (Зураг 2).



- Гараа угаана.
- Бээлий өмсөнө.
- Үйлчлүүлэгчээ тохиромжтой байрлалд (хэвтээ эсвэл суугаа) байрлуулна.
- Судас хатгах талбайг сонгоно.
- Хатгах судаснаас 2-4 см орчим дээр чангалуурыг зөвхөн хураагуурын цусны урсгалыг хааж, тараагуур судасны лугшилт мэдэгдэж байхаар бэхэлнэ.
- Цусны урсгалын дагуу арьсыг арчиж ариутгана (Зураг 3).



- Зүү тариураа арьстай 10-15 хэмийн налуугаар судсаа чиглүүлэн, арьсыг, дараа нь судсыг хатгана (Зураг 4).



- Зүү судсанд орсон тохиолдолд хуруу шилээ(вакутейнер) тосч, шинжилгээний зорилгоос хамаарч 10-18 мл цус авна (Зураг 5).
- Шинжилгээнд цус авч дууссаны дараа чангалуурыг суллан, хөвөн бөмбөлгөөр дарж, зүүг сугалж авна (Зураг 6).



Үйлдлийн дараа

- Зүүг сугалж авсны дараа наалдуулагч бүхий лентээр тогтоож өгнө.
- Цусыг лабораторт шинжилгээний бичгийн хамт явуулна (Зураг 7).
- Халуун зүйл уухыг санал болгож, хэсэг хугацаанд үйлчлүүлэгчийг хяналтад байлгана.
- Хэрэглэсэн зүү тариураа салгахгүйгээр, дахин таглахгүйгээр аюулгүй хайрцагт хийнэ.
- Хэрэв зүүг зайлшгүй таглах бол аюулгүй таглах “нэг гарын” дүрмийг баримтлан гар хүргэхгүйгээр таглана.
- Тарилгын хог хаягдлыг зааврын дагуу ангилан устгалд бэлтгэнэ.
- Бээлийг тайлна.
- Гараа угаана.



Анхаарах зүйлс:

- Чангалуурыг зөв тавих
- Зүүг зөв сонгох
- Бэлтгэх бүх явцад материалууд ариун байх
- Зүүг зүүний хамгаалалтаас гаргасны дараагаар маш болгоомжтой хандах
- Хамгаалалтгүй зүүг юунд ч хүргэж болохгүй. Ажилбартаа анхаарлаа төвлөрүүлэх
- Бохирлогдсон зүйлийн халдвар тараах эсэхийг шалгах

Үйлдлийн гүйцэтгэлд явцын болон эцсийн хяналт тавигч: Сувилагч, ахлах сувилагч, бага эмч, их эмч

ЦУСАНД ГЛЮКОЗЫН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=UwCSbR35d9A>

Түлхүүр үг: Цусанд глюкоз тодорхойлох арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго : Оношилгоо, эмчилгээний

Заалт: Эмчийн заалтаар цусан дахь глюкозын хэмжээг тодорхойлох



Эсрэг заалт: Байхгүй

Хэрэглэгдэх зүйлс:

1. Глюкометрийн тест
2. Глюкометр
3. Нэг удаагийн өндөг хатгагч
4. Ариун хөвөн бөмбөлөг
5. Бээлий
6. Аюулгүй хайрцаг
7. Халдвартай хог хаягдлын уут, сав



Үйлдлийн өмнө: Хэрэглэгдэх зүйлсээ бэлтгэнэ.

ҮЙЛДЛИЙН ЯВЦ:



- Үйлчлүүлэгчийн өрөөний хаалгыг нь тогшиж, зөвшөөрөл авч өрөөнд нь орно.
- Үйлчлүүлэгчийнхээ нэрээр нь дуудаж мэндэлнэ.
- Үйлчлүүлэгчид өөрийнхөө нэр, албан тушаалыг танилцуулна.
- Хийх ажилбарын зорилгыг танилцуулна.
- Үйлчлүүлэгчийг ажилбарт бэлэн эсэхийг асууна (Зураг 1).
- Үйлчлүүлэгчийг танихдаа овог нэр, төрсөн он, сар, өдрөөр нь дахин тулгаж хянана.
- Шинжилгээнд хэрэглэгдэх зүйлсийн бүрэн бүтэн байдал, ариун чанар ба хүчинтэй хугацааг шалгана (Зураг 2).
- Зүү, тариурын бүрэн бүтэн байдал, ариун ба хүчинтэй хугацааг шалгана.
- Гар халдваргүйжүүлэх уусмалаар гараа халдваргүйжүүлнэ.
- Нэг удаагийн бээлий өмсөнө.
- Үйлчлүүлэгчээ тохиромжтой байрлалд /хэвтээ эсвэл суугаа/ байрлуулна.
- Хэрэглэгдэх зүйлсийн хүчинтэй хугацаа, бүрэн бүтэн байдлыг шалгаж үйлчлүүлэгчид тайлбарлана.
- Глюкометрт тестээ хийнэ. Тестний хайрцаг дээрхи код гарч ирэхийг хүлээнэ (Зураг 3).
- Хатгах талбайг сонгоно.
- Үйлчлүүлэгчийн зүүн гарын алгыг дээш харуулан ядам хурууг чимхэж барина.



- Спирттэй хөвөн бөмбөлгөөр хурууны өндөгний гадаргууг төвөөс гадагш чиглэлээр арчиж ариутгана. Хуурай хөвөн бөмбөлгөөр үлдэгдэл спиртийг шингээж авах ба хуурай болтол арчина (Зураг 4).
- Нэг удаагийн өндөг цоологчоор эргүүлэх маягаар өндгийг хатгана (Зураг 6). Хатгасан өндөг цоологчийг аюулгүй хайрцагт хийнэ.
- Хурууг болгоомжтой шахаж, эхний дусал цусыг хуурай хөвөн бөмбөлгөөр арчина.
- Глюкометрийн ирмэгээс барьж үйлчлүүлэгчийн хурууг болгоомжтой шахаж, хоёр дахь дусал цусыг тестний үзүүрт дусаана (Зураг 7).
- Хуруунд үлдсэн цусыг спирттэй хөвөн бөмбөлгөөр арчиж дарна. 5 секундын дараа хариу гарна (Зураг 8).



Үйлдлийн дараа:

- Хэрэглэсэн глюкозын тестийг аюулгүй хайрцагт хийнэ.
- Хог хаягдлыг зааврын дагуу ангилан устгалд бэлтгэнэ.
- Бээлий тайлна.
- Гараа угаана.
- Хариуг үйлчлүүлэгчдэд тайлбарлан өгч бичиж тэмдэглээд үйлчлүүлэгчийг эргэн хянана.

ДАВСГАНД ГУУРС БАЙРЛУУЛАХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=oWY0fvFvjmk>

Түлхүүр үг: Эмчлүүлэгчид шээлгүүр тавих арга техник

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Давсганд хуримтлагдсан шээсийг гадагшлуулах

Тодорхойлолт: Тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчид нэмэлт зовиур үүсгэхгүйгээр мэргэжлийн өндөр түвшинд, хөнгөн, шуурхай үзүүлэхэд оршино.

Заалт:

- Давсгийг угаах
- Давсгийг дурандаж шинжлэх
- Давсганд эмийн бодисыг хийх
- Шээс задгайрал (мэдрэлийн системийн эмгэгтэй холбоотой)
- Шээс хаагдсан тохиолдолд давсганд хуримтлагдсан шээсийг гадагшлуулах
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ



ЭСРЭГ ЗААЛТ:

- Давсаг шээсний замаас цус алдаж байгаа үед
- Давсаг шээсний замын чулуутай үед
- Давсагны хурц үрэвслийн үед
- Бөөр давсагны хавдрын үед

Хэрэглэгдэх зүйлс:

1. Бээлий 2 ширхэг (ариун бээлий 1 ширхэг)
2. Хөвөн бөмбөлөг
3. Ариун шээлгүүр (8Fr-16Fr)
4. Ариутгалын уусмал (10%-ийн повидон иод, 1-2%-ийн хлоргексидины уусмал)
5. Шээс шинжилгээнд авах тагтай ариун сав
6. Ариун шээсний уут
7. Тариур
8. Нэрмэл ус
9. Наалт
10. Зориулалтын гель (өвдөлт багасгах)
11. Бөөр хэлбэрийн таваг
12. Ариутгасан багаж (хямсаа)
13. Нүхтэй даавуу
14. Хулдаас
15. Хөтөвч (шээсний уут)
16. Шаардлагатай бол орны өмнүүр хаалт эсвэл хөшиг хэрэглэнэ



ҮЙЛДЛИЙН ТЕХНОЛОГИ

ҮЙЛДЛИЙН ӨМНӨ:


- Хэрэглэгдэх зүйлсийг бэлтгэнэ. Үйлдлийн зорилго, ач холбогдол, явц, гарч болзошгүй хүндрэл, үйлдлийн үед эмчлүүлэгчийн хүлээх үүргийн талаар урьдчилан ярьж ойлгуулсан, таниулсан байна.

ҮЙЛДЛИЙН ЯВЦ:



Эрэгтэй эмчлүүлэгчид

- Эмчлүүлэгчийн өрөөний хаалгыг тогшин, зөвшөөрөл авч өрөөнд орно.
- Эмчлүүлэгчтэй мэндлэн өөрийгөө танилцуулна
- Эмчлүүлэгчийнхээ нэрийг асууна, ярилцах боломжгүй хүнд хэвтрийн эмчлүүлэгчийн гарт зүүсэн бугуйвчин дээрх нэрийг шалгана
- Ажилбарт бэлэн эсэхийг асууна.
- Ажилбарыг эмчлүүлэгчид түвэг учруулахгүй гүйцэтгэх
- Хэрэглэгдэх зүйлсийг гарт ойр аль болох тохиромжтой байрлалд байрлуулна.
- Тусламж үзүүлэгч гараа угааж, бээлийгээ өмсөнө.
- Үйлчлүүлэгчийг хэвтээ байрлалд байрлуулж, хувцсыг тайлуулан гадна бэлэг эрхтэнг ил гаргаж бэлдэнэ. (Зураг 1).
- Эмчлүүлэгчийн өгзгийг өргөж, хулдаас жийрэг даавууг өгзгөн доогуур дэвсэж өгнө.
- Бөөр хэлбэрийн тавгийг бэлэг эрхтэний ойр байрлуулна.
- Тусламж үзүүлэгч бээлийгээ тайлан, гарыг халдваргүйжүүлэн ариун бээлий өмсөнө.
- Шээлгүүрийг ариун шээсний ууттай холбож, 5-10 мл нэрмэл усыг тариурт соруулаад, шээлгүүрийн бөмбөлөг зөв үүсэж байгааг шалгана. Шалгасны дараа тариураар нэрмэл усыг соруулан авч, бөмбөлгийг шахаж хэвийн байдалд оруулна (Зураг 2,3).
- Нэг удаагийн ариун шээлгүүрийн багцыг эмчлүүлэгчийн 2 хөлний завсар тавина.



- Ариутгалын уусмалыг гарган зориулалтын саванд хийн (10%-ийн повидон иод, 1-2%-ийн хлоргексидины уусмал) хөвөн бөмбөлөгнүүдийг норгож бэлтгэнэ. Мөн зориулалтын гелийг савнаас нь гаргаж бэлдэнэ.
- Ариун даавууг гаргаж нүхийг нь эмчлүүлэгчийн бэлэг эрхтэнд тааруулж тавина (Зураг 4).
- Зүүн гарын эрхий долоовор хуруугаар бэлэг эрхтний толгой хэсгийг барьж, баруун гараар ариутгасан хямсаагаар норгосон хөвөн бөмбөлгөөс авч шээсний сүвийг ариутгалын уусмалаар арчиж ариутгана (Зураг 5).
- Баруун гараар тохирох шээлгүүрийг сонгон авч барина.
- Шээлгүүрийн үзүүрийг зориулалтын гель-ээр чийгшүүлэн, жигд хөдөлгөөнөөр шээсний сүвэнд зөөлөн имэрч оруулаад цааш түлхэж өгнө (Зураг 6,7).
- Шээс нь катетераар гарч ирснийг шалгасны дараа шээлгүүрийг шээсний сүвэнд үлдээхийн тулд гуурсаар шээлгүүрийн хэмжээнд (хэмжээс тус бүрт бичигдсэн шингэний хэмжээг харах) тохирох шингэн эсвэл хий шахан бөмбөлөг үүсгэж, шээлгүүрийг болгоомжтой зөөлөн татаж шалгана (Зураг 8,9). Эмчлүүлэгчийн гуяны дотор хэсэгт бэхэлж наана (Зураг 10).
- Шээлгүүрийг шээсний уутны хамт эмчлүүлэгчийн орны хөлөнд бэхэлнэ. (Зураг 11).



Эмэгтэй эмчлүүлэгчид

- Эмчлүүлэгчийн өрөөний хаалгыг тогшин зөвшөөрөл авч өрөөнд орно.
 - Эмчлүүлэгчтэй мэндлэн өөрийгөө танилцуулна
 - Эмчлүүлэгчийнхээ нэрийг асууна, ярилцах боломжгүй, хүнд хэвтрийн эмчлүүлэгчийн гарт зүүсэн бугуйвчин дээрх нэрийг шалгана
 - Ажилбарт бэлэн эсэхийг асууна.
 - Ажилбарыг эмчлүүлэгчид түвэг учруулахгүй гүйцэтгэх
 - Хэрэглэгдэх зүйлсийг гарт ойр аль болох тохиромжтой байрлалд байрлуулна.
 - Тусламж үзүүлэгч гараа угааж, бээлийгээ өмсөнө.
 - Эмчлүүлэгчийг хэвтээ байрлалд байрлуулан, хувцсыг тайлуулан, гадна бэлэг эрхтэнг ил гаргаж бэлдэнэ (Зураг 1).
-
- Эмчлүүлэгчийн өгзгийг өргөж, хулдаас даавууг өгзгөн доогуур дэвсэнэ.
 - Тусламж үзүүлэгч бээлийгээ тайлан гарыг халдваргүйжүүлэн ариун бээлий өмсөнө.



- Шээлгүүрийг ариун шээсний ууттай холбож, 5-10 мл нэрмэл усыг тариурт соруулаад, шээлгүүрийн бөмбөлөг зөв үүсэж байгааг шалгана. Шалгасны дараа тариураар нэрмэл усыг буцаан соруулан авч, бөмбөлгийг шахаж хэвийн байдалд оруулна (Зураг 2,3).
- Ариутгалын уусмалыг гарган зориулалтын саванд хийн (10%-ийн повидон иод, 1-2%-ийн хлоргексидины уусмал) хөвөн бөмбөлөгнүүдийг норгож бэлтгэнэ. Мөн зориулалтын гелийг савнаас нь гаргаж бэлдэнэ.
- Нэг удаагийн ариун шээлгүүрийн багцыг эмчлүүлэгчийн 2 хөлний завсар тавина.
- Ариун даавууг гаргаж нүхийг нь эмчлүүлэгчийн бэлэг эрхтэнд тааруулж тавина (Зураг 4).
- Зүүн гарын эрхий долоовор хуруугаар бэлгийн их уруулыг 2 тийш нь дэлгэн, шээсний сүвийг харж шалган, баруун гараар ариутгасан хямсаагаар норгосон хөвөн бөмбөлгөөс авч, шээсний сүв болон гадна бэлэг эрхтний их уруул, бага уруулыг дээрээс нь доош нь чиглэлтэй арчиж ариутгана (Зураг 5).
- Баруун гараар тохирох шээлгүүрийг сонгон авч барина.
- Шээлгүүрийн үзүүрийг зориулалтын гель-ээр чийгшүүлэн, жигд хөдөлгөөнөөр шээсний сүвэнд зөөлөн оруулна (Зураг 6,7).



- Шээс нь катетераар гарч ирснийг шалгасны дараа шээлгүүрийг шээсний сүвэнд үлдээхийн тулд гуурсаар шээлгүүрийн хэмжээнд (хэмжээс тус бүрт бичигдсэн шингэний хэмжээг харах) тохирох шингэн эсвэл хий шахан бөмбөлөг үүсгэж, шээлгүүрийг болгоомжтой зөөлөн татаж (Зураг 8,9) шалгаад эмчлүүлэгчийн гуяны дотор хэсэгт бэхэлж наана (Зураг 10).



- Шээлгүүрийн шээсний уутны хамт эмчлүүлэгчийн орны хөлөнд бэхэлнэ (Зураг 11).

ҮЙЛДЛИЙН ДАРАА:

- Үйлчлүүлэгчийн ор дэвсгэрийг засаж, дулаан хучиж хэвтүүлнэ.
- Хог хаягдлаа ангиллын дагуу устгана.
- Үйлдлийн дараа бээлийг тайлан, гараа угаана.
- Үр дүнг сувилгааны тэмдэглэлд бичнэ.



АНХААРАХ ЗҮЙЛС:

- Шээсний сүв гэмтээх, өгсөх замаар халдвар орохоос сэргийлэх
- Шээсний сүвийг гэмтээснээс давсагнаас цус алдах
- Шээлгүүрийг тослоогүй хийснээс салст бүрхэвчийг гэмтээх
- Давсаг угаах тохиолдолд хэт халуун ба хэт хүйтэн уусмалаар угааснаас давсагны салст бүрхэвчийг цочроох зэрэг гарч болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх
- Үйлдлийг эмчлүүлэгчийн өрөөнд хийсэн тохиолдолд эмчлүүлэгчийн хувийн эрхийг хүндэтгэх үүднээс ор тусгаарлагч эсвэл хөшиг хэрэглэх, хэрвээ үйлчлүүлэгч хүссэн тохиолдолд тусгай ажилбарын өрөөнд үйлдлийг гүйцэтгэх



12



13

- ❖ Шээлгүүрийг сонгохдоо үйлчлүүлэгчийн нас, хүйс, биеийн байдалд тохируулах ба ихэвчлэн 8Fr-аас 16Fr хүртэл хэмжээстэй шээлгүүрээс сонгон хэрэглэдэг.
- ❖ Шээлгүүрийн бөмбөлгийг дүүргэх хий эсвэл шингэний шахах хэмжээ нь тухайн шээлгүүрийн шингэн шахах үзүүрт бичээстэй байгааг харж хэмжээсний дагуу бөмбөлөг үүсгэнэ (Зураг 12- Foley catheter).
- ❖ Шээлгүүр нь байнгын буюу Foley catheter байхаас гадна нэг удаагийн шээлгүүрийг шээсийг хурдан хугацаанд авах зорилгоор хэрэглэдэг. Нэг удаагийн шээлгүүр нь хий шахан бөмбөлөг үүсгэх хэсэг байхгүй, нэг замтай байдаг (Зураг 13- Нэг удаагийн шээлгүүр).

Үйлдлийг гардан гүйцэтгэгч: Сувилагч, бага эмч, их эмч

Үйлдлийн гүйцэтгэлд явцын болон эцсийн хяналт тавигч: Сувилагч, ахлах сувилагч, бага эмч, их эмч

ЭХ БАРИХЫН ГАРДАН ҮЙЛДЭЛ: ГАДУУР ҮЗЛЭГ



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=5-my1aoy1tw>

Түлхүүр үг: ЭБЭ Эх барихын гадуур үзлэг

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Умайн ёроолын өндөр, ургийн байрлал, нуруулалт, янз, ургийн түрүүлсэн хэсэг зэргийг тодорхойлж ургийн байдалд үнэлгээ өгөх

Заалт: Жирэмсний 5 сартайгаас хойшхи хугацаатай жирэмсэн эхийг энэхүү аргаар шинжилнэ.



Эсрэг заалт: Байхгүй

Хэрэглэгдэх зүйлс: Хатуу гадаргуутай ор

Бэлтгэл: Үзлэг хийхээс өмнө эмэгтэйд үзлэгийн талаар хэлж тайлбарлан зөвшөөрөөл авна. Эмэгтэйг үзлэг эхлэгээс өмнө шээлгэж, давсагийг сулласан байна.

Үйлдэл хийх арга техник: Жирэмсэн эмэгтэйг хатуу, тэгш гадаргуутай орон дээр дээш харуулж, хөлийн өвдгөөр нь ялимгүй нугалуулж хэвтүүлнэ. Үзлэгийг Леопольд –Левицкийн дэс дараалсан 4 барилаар хийнэ: Үзлэг хийж буй хүн эмэгтэйн баруун талд зогсож хийнэ.



1- р барил: Үзлэг хийхдээ эмч, эх баригч нь 2 гарын алганы ирмэгээр умайн ёроол дээр болгоомжтой дарж умайн ёроолын өндрийг тодорхойлж, ургийн ямар хэсэг байгааг тэмтэрнэ (Зураг 1).




2-р барил: Эмч, эх баригч нь 2 гарын алгыг умайн хоёр талд байрлуулж, зөөлөн гулсуулах маягаар тэмтэрч ургийн байрлал, ургийн нуруулалт, хэлбийлт зэргийг тодорхойлно. Ургийн байрлал дагуу, ташуу, хөндлөн байдлаар тэмтрэгдэж болно. Ургийн нуруу эхийн зүүн талд тэмтрэгдвэл 1-р нуруулалт, баруун талд тэмтрэгдвэл 2-р нуруулалт гэж үзнэ. Хэрэв ургийн нуруу эхийн хэвлий тал руу хандсан бол урд хэлбийлт, ургийн нуруу эхийн ар нуруу руу хандсан бол арын янз гэж үзнэ (Зураг 2).



3-р барил: Ургийн түрүүлсэн хэсгийг тодорхойлно. Баруун гарын эрхий болон дунд хуруугаар умдагны дээгүүр, умайн доод таславчны орчмоор тэмтэрч ургийн түрүүлсэн хэсгийг тэмтэрнэ. Хэрэв толгой түрүүлсэн бол бөөрөнхий, хатуу, хөдөлгөөнтэй зүйл тэмтрэгдэнэ, хэрэв өгзөг түрүүлсэн бол багтаамж томтой, харьцангуй зөөлөн, хөдөлгөөн багатай зүйл тэмтрэгдэнэ (Зураг 3).



4-р барил: Эмэгтэйн хөл рүү харж ургийн түрүүлсэн хэсэг аарцгийн орох хэсэгт хэр зэрэг суусныг тодорхойлно. 2 гарынхаа эрхий хуруунаас бусад хурууныхаа үзүүрийг эхийн хэвлийн гадна талаас нь ургийн түрүүлсэн хэсэг ба бага аарцгийн орох амсрын хооронд байрлуулж, тодорхойлно (Зураг 4).



Зураг 5. Ургийн толгойн тавилтыг 5-тын аргаар үнэлэх

Энэ аргаар ургийн толгой бага аарцгийн орох хэсэгт тавигдсан, бага бүслүүрээр суусан, их бүслүүрээр суусан, аарцгийн хөндийд орсон, гарах хэсэгт ирсэн г.м.ээр үнэлнэ.

Сүүлийн үед энэ аргыг хялбарчилсан хэлбэрээр 5-тын аргаар үнэлэх болсон. Эмч, эх баригч баруун гарын 5 хуруугаар умдагны дээр байрлуулж хэрэв 5 хуруунд толгой тэмтрэгдэж байвал 5/5, 4 хуруунд тэмтрэгдэж байвал 4/5, 3 хуруунд тэмтрэгдэж байвал 3/5 г.м- ээр үнэлж, хэрэв аарцгийн хөндийд орсон бол 0/5 гэж үзнэ (Зураг 5).

АНХААРАХ: Эхийг орон дээр дээш харуулан удаан хугацаагаар хэвтүүлэх нь доод хөндийн венийн судасны дарагдал үүсэж, дотор муухай оргих бөөлжих, даралт буурах шинжүүд илэрч болохыг анхаарах хэрэгтэй.

Үзлэгийн үргэлжлэх хугацаа: 10 -15 минут.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч : Ерөнхий болон эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч

ЭХ БАРИХЫН ГАРДАН ҮЙЛДЭЛ:УМАЙН ЁРООЛЫН ӨНДӨР ҮЗЭХ



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=vq1ubWNpzwQ>
2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Түлхүүр үг: ЭБЭ Умайн ёроолын өндөр хэвлийн тойрог хэмжих

Зорилго: Жирэмсний тээлтийн хугацаа, ургийн өсөлтийг тодорхойлох

Заалт: Жирэмсний 4 сартайгаас эхлэн умайн ёроолын өндрийг үзлэг хийх бүрт хэмжинэ.



Эсрэг заалт: Байхгүй

Хэрэглэгдэх зүйлс:



Хатуу гадаргуутай ор



Хуваарьтай тууз



Аарцаг хэмжигч
хэмжигч

Үйлдэл хийх арга техник:

Умайн ёроолын өндрийг эх барихын гадуур үзлэгээр болон туузан метрээр хэмжиж тодорхойлно.

- Үйлдэл хийхээс өмнө эмэгтэйд үзлэгийн ач холбогдлыг тайларлана.
- Жирэмсэн эмэгтэйг шээлгэсний дараа орон дээр хэвтүүлнэ.
- Туузан метрээр хэмжихээр бол: нэг үзүүрийг умдагны үений дээд ирмэгт нөгөө үзүүрийг умайн ёроолд байрлуулж хэмжээг харж тогтооно.
- Эх барихын гадуур үзлэгээр хоёр гарын алганы ирмэгээр умайн ёроолд дарж тодорхойлно.
- Умайн ёроолын өндрийн хэвийн хэмжээнүүд нь:
 - 4 сартайд 6-7 см (умдагны үеэс дээш 4 хуруу)
 - 5 сартайд 12-13 см (умайн ёроол хүйснээс доош 2 хуруу орчимд)
 - 6 сартайд 20-24 см (хүйсний орчимд)
 - 7 сартайд 24-28 см (хүйснээс дээш 2-3 см)
 - 8 сартайд 28-30 см (умайн ёроол хүйс, аймхай мөгөөрсний хооронд)
 - 9 сартайд 32-34 см (умайн ёроол аймхай мөгөөрс хавирганы нумд тулсан)
 - 10 сартайд 28-32 см (8 сарынхтай ижил хэмжээтэй)


Хэвлийн тойргийг хэмжихдээ туузан метрийг хүйсний түвшинд хэвлийг тойруулж чангавтар татаж хэмжинэ (Зураг 1,2).



Зураг 1. Хэвлийн тойрог хэмжих



2. Умайн ёроолын өндрийг хэмжих



Зураг 3. Эх барихын гадуур үзлэгээр умайн ёроолын өндрийг хэмжих ба жирэмсний хугацаа



АНХААРАХ: Ихэр жирэмсэн, ураг орчмын шингэн хэт их эсвэл хэт бага, ургийн байрлал буруу байгаа үед дээрх хэмжээс өөрчлөгдөнө.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч: Их, бага эмч

ЭБЭ-ИЙН ГАРДАН ҮЙЛДЭЛ: ҮТРЭЭНИЙ ҮЗЛЭГ



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=fTGiLCcmLbY>

- Түлхүүр үг:** ЭБЭ Эмэгтэйчүүдийн үтрээний үзлэг хийх
2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Гадна, дотор бэлэг эрхтэний хэвийн ба эмгэг байдлыг илрүүлэх

Заалт: Эмэгтэйчүүдийн үзлэг хийх шаардлагатай бүх тохиолдлуудад




Эсрэг заалт:

- Охин хальс сэвтээгүй бүтэн
- Үтрээний наалдац бүхий өөрчлөлт
- Үтрээгүй эсвэл үтрээгээр үзлэг хийх боломжгүй гаж хөгжил
- Хөгшрөлтөөс болоод үтрээний үүдэвч, ханын уян хатан чанар алдагдсан.

Бэлтгэл: Эмэгтэйг үзлэг хийхээс өмнө шээлгэж давсгийг суллана. Хийх гэж буй үйлдлийг тайлбарлаж, эмэгтэйгээс зөвшөөрөл авна. Үзлэгийн өрөө тав тухтай цэвэр, дулаан, ганцаарчилсан үзлэг хийх нөхцлийг хангасан байна.

Үйлдлийн арга техник: Үйлчлүүлэгчийг эмэгтэйчүүдийн орон дээр хэвтүүлнэ

Үйлдлийн үе шат: Гадна бэлэг эрхтэний байдлыг ажиглаж үнэлнэ: Умдагны үсний хэлбэр, (эрэгтэй, эмэгтэй) бэлгийн их, бага уруул, хэлүү, охин хальс, үтрээний үүдэвч, түүний булчирхай, өөр бусад эмгэг өөрчлөлт байгаа эсэхийг үзэж тодруулна.




Зураг 3. Үтрээний үзлэг хийж буй байдал (анатомийн бүтцээр)

- Эмч гараа угааж, ариун бээлий өмсөн, зүүн гарын эрхий долоовор хуруугаар бэлгийн их уруулыг хоёр тийш нь дэлгэж баруун гарын 2 (долоовор, дунд) хурууг үтрээнд болгоомжтой оруулна (Зураг 1).

Үтрээний үзлэгээр дараах зүйлсийг тодорхойлно:

- Үтрээний байдлыг үнэлнэ: багтаамж (уйтан, уужим), хана ба хүнхрээнүүдийн байдал, эмгэг өөрчлөлт байгаа эсэхийг тодруулна
- Умайн хүзүүний хэлбэр (шовгор, бортгон), цуллаг, урт, хөдөлгөөн, эмзэглэлтэй эсэх зэргийг тодорхойлно.
- Цаашид үтрээ хэвлийн хананы хавсарсан буюу 2 гарын үзлэгээр умайн (байрлал, хэмжээ, цуллаг, хөдөлгөөн, эмзэглэл г.м.) ба дайвруудын байдлыг (томорсон, эмзэглэлтэй эсэх, цуллаг, гадаргуун байдал г.м.) тэмтэрч үзнэ (Зураг 2).

 **АНХААРАХ ЗҮЙЛС:** Халдвар хамгааллын дэглэм чанд мөрдөнө.

Үйлдлийг гардан гүйцэтгэгч: Үтрээний үзлэгийг ерөнхий мэргэжлийн болон эх барих эмэгтэйчүүдийн эмч хийнэ.

Үйлдлийн гүйцэтгэлд явцын болон эцсийн хяналт тавигч: Үзлэг хийсэн эмч хяналт тавих ба үзлэгийн үнэлгээг хариуцна.

ЭБЭ-ИЙН ГАРДАН ҮЙЛДЭЛ: ААРЦАГ ХЭМЖИХ



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=iVbjl-8cLgA>

Түлхүүр үг: ЭБЭ Аарцаг хэмжих арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Жирэмсэн эмэгтэйчүүдийн аарцгийн хэлбэр, хэмжээг тогтоох

Заалт: Жирэмсэн эмэгтэйд



Эсрэг заалт: Байхгүй

Хэрэглэгдэх зүйлс:

1. Аарцаг хэмжигч
2. хатуу гадаргуутай ор



ААРЦАГ ХЭМЖИХ АРГА ТЕХНИК:

Аарцаг хэмжигчээр их аарцгийн 3 хөндлөн, 1 шулуун хэмжээг тогтооно. Шаардлагатай үед аарцгийн гарах хэсгийг хэмжиж болно.



1. Эмэгтэйд аарцаг хэмжих үйлдлийн тухай тайлбарлаж ойлгуулна (Зураг 1).

2. Жирэмсэн эмэгтэйг хатуу орон дээр дээш харуулан хэвтүүлж, аарцаг хэмжигчийн хоёр талаас гараараа барьж, 2 гарын долоовор хуруугаар хэмжих газраа тогтоож, товчийг байрлуулан, аарцаг хэмжигчийн хэмжээг харж тодорхойлно.

3. Ташаа ясны урд дээд сэртэн хоорондох зайг хэмжинэ. Хэвийн үед 25-26 см (Зураг 2).


4. Ташааны ясны дэлбээний хамгийн алслагдсан зайг хэмжинэ. Аарцаг хэмжигчийн товчийг эхний хэмжилт хийсний дараа салгахгүйгээр цааш гуулгуулан хэмжих цэгт байрлуулна. Хэвийн үед 28-29 см (Зураг 3).



5. Түнх хоорондын зай буюу дунд чөмөгний ясны толгойн товгорын хоорондох зай. Хэвийн үед 30-31 см (Зураг 4).

6. Гадна шулуун хэмжээ: Эмэгтэйг аль нэг хажуу талаар нь хэвтүүлж доод талын хөлийг өвдөг түнхний үеэр нь нугалж, дээд хөлийг жийлгэж байрлуулна. Аарцаг хэмжигчийн нэг товчийг умдагны гадна, дээд ирмэг дээр, нөгөө товчийг зоо нурууны Ромбын дээд өнцөгт тавьж хэмжинэ. Хэвийн үед 20-21 см байна (Зураг 5).



 **АНХААРАХ ЗҮЙЛС:** Хэмжилтийг буруу хийвэл төрөлт удирдах үед алдаа гарч, эх ба ураг, нярай хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө гэдгийг анхаарах хэрэгтэй.

Үйлдлийг хийж гүйцэтгэгч: Их, бага эмч гүйцэтгэнэ.

УМАЙН ХҮЗҮҮНИЙ ЭСИЙН ШИНЖИЛГЭЭ АВАХ АРГА



Дүрс бичлэг үзэх:

1. Доорх холбоос дээр дарж татаж үзэх:
<https://www.youtube.com/watch?v=5UG3GE2A6ik>

Түлхүүр үг: ЭБЭ Умайн хүзүүний эсийн шинжилгээ авах арга

2. QR кодыг уншуулан дүрс бичлэгийг үзэх:

Зорилго: Умайн хүзүүний эмгэг өөрчлөлт, өмөнгийн урьдал болон өмөнг эрт илрүүлэх

Шаардлагатай багаж материал:

1. Гар угаах ус, саван, арчих сальфетка
2. Умайн хүзүүг харах хажуугийн гэрэл
3. Цэвэр даавуугаар бүтээсэн үзлэгийн ширээ
4. Эмэгтэйчүүдийн ор
5. Эсийн шинжилгээнд илгээх маягт
6. Бохир багаж хэрэгсэл хаях хогийн сав
7. Багаж ариутгах 0,5% хлорын уусмал



Шинжилгээний хэрэглэгдэхүүн

1. Нэг удаагийн эсвэл ариун бээлий
2. Нэг удаагийн эсвэл ариутгасан толь
3. Модон хусуур эсвэл пластик сойз
4. Шинжилгээний тавиур шил, хаяг бичих шилний харандаа
5. Бэхжүүлэгч уусмал (95%-ийн этанолын уусмал)

Дараах нөхцөлд эсийн шинжилгээ авахгүй

- Бэлэг эрхтний хурц халдвартай
- Биений юм ирж байгаа үед
- Бэлгийн хавьтал хийснээс хойш, үтрээнд тампон чихээс хэрэглэснээс хойш, үтрээнд жирэмслэхээс сэргийлэх болон эмчилгээний зорилгоор эм хэрэглэсэнээс хойш 24-48 цагийн дотор.


Бэлтгэл

- Шинжилгээний ач холбогдлын талаар болон шинжилгээ авах арга, үр дүнгийн талаар тайлбарлаж ойлгуулна.
- Эмэгтэйгээс ажилбар хийлгэх зөвшөөрөл авна.
- Шинжилгээний тавиур шилний цантай хэсэгт эмэгтэйн сорьцын дугаар, огноог бичнэ.

ЭСИЙН ШИНЖИЛГЭЭ АВАХ АРГА ТЕХНИК




1. Эмч шаардлагатай зүйлсийг бэлтгэж өвчтөнд ажилбарын талаар тайлбарлана. Эмч гараа ариутгаж, бээлий өмсөнө.
2. Эмэгтэйг шээлгэсний дараа эмэгтэйчүүдийн үзлэгийн орон дээр хэвтүүлнэ.
3. Үтрээнд толь тавина: Эсийн шинжилгээ авах үед толинд тос түрхэж болохгүй. Зүүн гарын эрхий долоовор хуруугаар бэлгийн их уруулыг 2 тийш дэлгэн, толийг нээхгүйгээр босоо чиглэлд барьж (Зураг 1), үтрээнд болгоомжтой зөөлөн оруулж 90° эргүүлэн хөндлөн байрлалд оруулж (Зураг 2), толийг нээж, умайн хүзүүг ил харагдахаар байрлуулаад толийг түгжинэ (Зураг 3).
4. Зориулалтын сойзны урт үзүүрийг умайн хүзүүний сувагт бүрэн оруулж, умайн хүзүүний суваг болон



Т зоныг хамруулан, нар зөв нэг бүтэн эргүүлж (360 хэм) шинжилгээг авна (Зураг 4).

5. Сойзоор авсан материалыг тавиур шилэн дээр нэгээс хоёр удаа, сойзыг хоёр талаар нь хөнгөн гулсуулж түрхэнэ. Шинжилгээ авсан хэсгээс өөр газар эмгэг байвал тэр хэсгээс тусад нь арчдас авч өөр шилэн дээр түрхэж бэхжүүлэн тэмдэглэнэ (Зураг 5).
6. Тавиур шилэнд түрхсэний дараа шууд 95%-ийн этанолын уусмалд 10-15 хором дүрж бэхжүүлнэ (Зураг 6).
7. Шинжилгээг авч дуусгасны дараа үтрээнээс толийг болгоомжтой авч, багажийг халдваргүйжүүлэх уусмалд хийн, хэрэглэсэн зүйлсийг хог хаягдлын ангилалын дагуу устгаж хаяна.
8. Эмч ажилбарын дараа бээлийг тайлан, гараа угаана.




Шинжилгээ авсны дараа

1. Өвчтөний картанд үзлэгээр шилжилтийн бүс харагдаж байсан эсэх, үрэвсэл, шархлаа, бусад эмгэгүүд, үтрээний шүүрэл, өөр шинжилгээ авсан эсэх зэргийг тэмдэглэнэ.
2. Шинжилгээний илгээх хуудсыг гаргацтай үнэн зөв бөглөнө (Зураг 7).
3. Эмэгтэйд асуулт байгаа эсэхийг лавлана.
4. Эмэгтэйд шинжилгээний хариугаа хэзээ, хаанаас ирж авахыг хэлж, эргэж хариугаа авахын чухлыг дахин тайлбарлана.
5. Зорилтот насны бүлгийн найз, хамаатан, гэр бүлийнхнээ авчирч шинжлүүлэхийг санал болгоно.

Хяналт

1. Эмэгтэйд эргэж ирэхэд шинжилгээний хариуг тайлбарлаж өгнө. Цаашид хэрхэхийг тайлбарлаж зөвлөнө.
2. Хэрэв шинжилгээний хариу сөрөг буюу хэвийн гарсан бол 3 жилийн дараа давтан шинжилгээ хийлгэхийг зөвлөнө.
3. Шинжилгээний хариу эерэг буюу өөрчлөлттэй гарсан бол хяналтанд авч мэргэжлийн эмчид илгээнэ.
4. Хэрэв шинжилгээний хариу эерэг гарсан үйлчлүүлэгч ирэхгүй бол холбоо барьж дуудаж ирүүлнэ.



АНХААР: Нийт эмэгтэйд, ялангуяа эмгэгтэй гарсан бүх эмэгтэйд шинжилгээний хариуг нь тайлбарлан хэлсний дараа эмчийн ажил бүрэн хийгдсэн гэж үзнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

- Гардан үйлдлийн гарын авлага:
- Аарцаг хэмжилт, MNS4621:2008
- Ази – Номхон Далайн Баруун Эргийн Бүсийн ЧШ хэвшинж 2-ын ажлын хэсэг. ЧШ хэвшинж 2-ын эмнэлзүйн удирдамж, 2005 он
- Арьсан дор тарилга хийх арга техник, MNS4621:2008
- Булчинд тарилга хийх арга техник, MNS4621:2008
- Бэртэж гэмтсэн хүнд үзүүлэх анхны тусламж, Санамж, ОХУ-ын онцгой байдлын яам, 2016 он
- Диабетын сургагч багшийн баримтлан ажиллах удирдамж, стандартын жагсаалт
- Ерөнхий мэс засал, Я.Бухаа, Л.Гэпил, 2010 он
- Зүрхний цахилгаан бичлэг, MNS4621:2008
- Захын хураагуур судсанд уян зүү тавих заавар, ЭМС-ийн Сайдын 2015 оны 496 дугаар тушаалын 1 хавсралт
- Микробиологийн лабораторийн шинжилгээнд зориулан сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх. Гарын авлага, УБ, 2013 он
- Насанд хүрэгсдийн амилуулах суурь тусламж, эмнэлзүйн удирдамж, ЭМЯ, 2011 он
- Нярай хүүхдийн захын хураагуур судсанд уян зүү тавих. MNS4621:2008
- Өрх, сумын түвшинд үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай анхан шатны тусламж, үйлчилгээ. Эрүүл мэндийн ажиллагсдад зориулсан сургалтын нэгдсэн багц, УБ 2017он
- Судсанд тарилга хийх арга техник, MNS 4621:2008
- Судсанд тарилга хийх арга техник, MNS4621:2008
- Сувилахуйн түгээмэл хэрэглэгддэг гардан ажилбарууд, Л.Хишигдэлгэр нар, УБ, 2015 он
- Сувилахуйд суралцагсдад, О.Сарантуяа, В.Даваахүү,
- Сувилахуйн мэргэжлээр төгсөгчдөд зориулсан эмнэлзүйн тохиолдлын эмхэтгэл, 2018 он

- Сувилгааны гардан ажилбарын гарын авлага, 2017 он
- "Умайн хүзүүний өмөн" эмнэл зүйн удирдамж, ЭМЯ, 2011 он
- Умайн ёроолын өндөр хэмжилт, MNS4621:2008
- Үйлчлүүлэгчид шээлгүүр тавих арга техник, MNS4621:2008
- Үтрээний үзлэг, MNS4621:2008
- Ходоодонд хаймсуур тавих, MNS4621:2008
- Хоол боловсруулах эрхтэний эмгэгийн анхан шатны эмнэлзүйн удирдамж, УБ 2012 он
- Хураагуур судас хатгаж, цус шинжилгээнд авах, MNS4621:2008
- Хүүхдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний өврийн лавлах, Зонхилон тохиолдох өвчнийг хязгаарлагдмал нөөц боломжтой нөхцөлд эмчлэх удирдамж. ДЭМБ
- Цусны шинжилгээ. Р.Мэнд-амар нарын, 2017 он
- Чихрийн шижин хэвшинж 2-ын эмнэлзүйн удирдамж
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 сарын 29 –ны өдрийн А/537 дугаар тушаал
- Эмчилгээ оношилгооны түгээмэл үйлдлийн стандарт, MNS 4621:2008
- Яаралтай тусламж, Г.Лхагважав 2010 он, хоёр дахь хэвлэл
- The Harriet Lane Handbook. The Johns Hopkins Hospital. 21th edition, Branden Engorn, Jamie Flerlage
- "Medscape"(<https://reference.medscape.com/article/80431-overview#a3>)
- Richard D.Zane "Pocket emergency medicine"
- Procedural GP 手技の力 Rural Generalist Program Japan, GENEPRO, 2018
- https://www.unboundmedicine.com/harriettlane/view/Harriet_Lane_Handbook/309868/all/Procedures
- <http://gemtel.mn/pages/%D0%B8%D0%BB-%D1%88%D0%B0%D1%80%D1%85%D0%B0%D0%BD%D0%B4-%D1%85%D0%B8%D0%B9%D1%85-%D0%B0%D0%BD%D1%85%D0%BD%D1%8B-%D1%82%D1%83%D1%81%D0%BB%D0%B0%D0%BC%D0%B6/>
- https://www.unboundmedicine.com/harriettlane/view/Harriet_Lane_Handbook/309868/all/Procedures)

